ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2020
№ 02; 03 (33)



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН СУРГУУЛЬ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

УЛИРАЛ ТУТМЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

Улаанбаатар хот
2020 он

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Б.Нямгомбо
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, хурандаа

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

А.Лхагва
Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор

Д.Даваа-Очир
Хууль зүйн доктор, профессор

Р.Оюунбадам
Шихихутаг хууль зүйн сургуулийн ахлах багш, хууль зүйн доктор

Б.Алтангэрэл
Хууль зүйн доктор, дэд профессор

Д.Дамдинцэрэн
Хууль зүйн доктор

С.Зул-Очир
Харуул хамгаалалтын тэнхимийн эрхлэгч, хурандаа

Д.Уранчимэг
Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, хурандаа

Б.Галбадрах
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.Мөнхбаатар
ШШГАС-ийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад

Эх бэлтгэсэн: Б.Мөнхбаатар
Хэвлэлийн хуудас: _____ х/х
Хэвлэлийн тоо: _____ ш

ISBN: 978-99978-770-2-4

“ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ” СЭТГҮҮЛ

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, Хилчний гудамж, Хууль Сахиулахын Их сургууль
Утас: +976-**70155009**
Факс: +976-**70155049**
И-мейл: munkhbaatar.b@leu.gov.mn
Веб: http://www.leu.gov.mn

ДУГААРЫН ТОВЧООН

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

I. ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ПРАКТИК

Б.Батболд, Б.Галбадрах, Г.Хосбаяр, Э.Өнөболд
Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага **6-26**

М.Хүрэлбат
Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажилд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан **27-41**

О.Баяржаргал
Гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй эмэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг судлах нь **42-53**

М.Досымбек
Хорих байгууллагын алба хаагчийн эрхийн байдлын ерөнхий асуудал:Харуул хамгаалалтын жижүүрийн бүрэлдэхүүн нойргүй ажилласнаас эрүүл мэндэд нь учирч буй хор уршгийн талаар **54-57**

II. ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ПРАКТИК

Б.Болор-Эрдэнэ
Хуулийн этгээдэд оногдуулах албадлагын арга хэмжээний хэрэгжилт **58-65**

Д.Намуун
Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын зарим асуудал **66-72**

III. БУСАД

М.Одбаяр
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтанд хамрагдах эрхийн хэрэгжилт **73-83**

Ж.Уганчимэг
Хүний эрх ба хүний наймаа **84-88**

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Уншигч, мэргэжил, зорилго нэгт Та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулиас уламжлал болгон эрхлэн гаргадаг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал” сэтгүүлийн 2020 оны 2, 3 дугаар улирлын дугаарыг Та бүхэнд хүргэж байгаадаа таатай байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/131 дүгээр тоот тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн бүтэц орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан төрөлх сургууль маань Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль гэсэн нэршилтэй болон өөрчлөгдөн зохион байгуулагдлаа.

Сэтгүүлд нийтэлсэн судлаачдын судалгаа шинжилгээ, холбогдох мэдээлэл, харьцуулсан судлалын үр дүн, дүгнэлт, санал-зөвлөмжүүд асуудлыг эргэцүүлэн бодож нягтлах, шийдлийг олох, эрх зүйн орчинг боловсронгуй болгох хийгээд эрдэмжих үйлд тань хувь нэмэр оруулна гэдэгт найдан санал бодлоо илэрхийлэхийг Та бүхнээс хүсье.

Хүндэтгэсэн:

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ХУРАНДАА
Б.НЯМГОМБО

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ ТӨРӨӨС НӨХӨН БАРАГДУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Б.БАТБОЛД
Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа



Б. ГАЛБАДРАХ
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/, хошууч



Г.ХОСБАЯР
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, хошууч



Э.ӨНӨБОЛД
Шүүийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн багш, ахмад

Хураангуй: Эрх зүйт төр нь ардчилсан ёс, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зэрэг үндсэн зарчмуудыг баримталдаг. Монгол Улсын Үндсэн хуульд “*Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна*” гэж заасан байдаг.

Ийнхүү төр нь иргэнийхээ өмнө үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан өнөө үед энэхүү үүрэг, хариуцлага өндөрсөж, төрийн зүгээс

иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг хамгаалах механизмын нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэх, арилгах буюу нөхөн төлүүлэх асуудал эрх зүйн болоод нийгмийн тулгамдсан асуудал болоод байна.

Түлхүүр үг: хохирол, нөхөн төлүүлэх, шударга ёс, нөхөн сэргээх.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”,“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Монгол Улсын Үндсэн хууль” болон бусад хууль тогтоомжуудад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хуулиар хүлээсэн байдаг.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал"(Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) батлагдсан нь дэлхийн улс орнуудадөөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогч судлалын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэрх зүйн гол үндэслэл болсон байна[1].

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 8 дугаар зүйл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан "Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчийн талаарх шүүн таслах ажиллагааны үндсэн зарчмуудын тухай” тунхаглал, 2005 онд баталсан "Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”, Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын 3.3-т "Төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Тухайн хохирлыг хариуцах Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна” гэж хохирол нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан дээрх баримт бичгүүдэд зааснаар буруутай этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах, төрөөс хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр,

[1] https://legal.un.org/avl/ha/dbpjvcap/dbpjvcap.html

сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн, шуурхай барагдуулах нөхцөл бололцоогоор хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлж ажиллахыг шаарддаг.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан бөгөөд бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтуудаар зохицуулсан байдаг.

АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Үндэсний хууль тогтоомжуудад хохирогчийн эрхийн байдлыг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх… эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна[2]”,

2. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэж тодорхойлоод мөн хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.9 дэх хэсэгт “гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах” эрхтэй[3],

3. Мөн хуулийн 8.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ”, 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд

[2]Монгол Улсын Үндсэн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992. №1.

[3]Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017. №23.

холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ”,

4. “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй” гэж тус тус хуульчилсан[4].

5. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.8-т “Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогын баримт бичгийг баталж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй дээрх эрх зүйн актуудаар нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээдийг хохирогч, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэж тодорхойлсон нь үндсэндээ эд хөрөнгийн хохирлоос гадна эд хөрөнгийн бус хохирол нөхөн төлүүлэх эрхийг бататган хуульчилсан бөгөөд ийнхүү гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг бататгасан нь эрх зүйн орчин бүрдсэн.

Нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийн нэг нь тухайн нийгмийн гишүүд аливаа хууль бус үйл ажиллагаанаас хохирох эрсдлээс баттай хамгаалагдсан байх явдал юм.

Гэмт хэрэг бол өөрөө нийгмийн амьдралын сөрөг үр дагавар бөгөөд улс орны эдийн засаг доройтож ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үнэ, инфляци өсөхийн хирээр гэмт хэргийн гаралт ч бас нэмэгдэж байдаг зүй тогтолтой. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг өсөхийн хирээр гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн тоо ч нэмэгдсээр байна.

Тэгвэл Монгол Улсын хувьд:

“Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-г бүрдүүлэхийг хуульчилсан байна[5].

Монгол Улсын Их Хурлаас “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийг 2006 оны 06 дугаар сарын 29-ний батлан, 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шинэчлэн найруулсан.

---

[4]Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002. №8.

[5] “Засгийн газрын нөөц сангийн тухай хууль” шинэчилсэн найруулга, 2019. // https://www.legalinfo.mn/law/details/14848?lawid=14848

Хүснэгт 1.

№	2006 оны хуулиар		2019 оны хуулиар	
	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	**Эрүүгийн хуулийн зүйл заалтын гарчиг**	**Эрүүгийн хуулийн зүйл, заалт**	**Эрүүгийн хуулийн зүйл заалтын гарчиг**
1	10.1 дүгээр зүйл	Хүнийг алах	10.1 дүгээр зүйл	Хүнийг алах
2	11.1 дүгээр зүйл	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	11.1 дүгээр зүйл	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах
3	12.1 дүгээр зүйл	Хүчиндэх	11.4 дүгээр зүйл	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах
4	13.3 дугаар зүйл	Хүн барьцаалах	12.1 дүгээр зүйл	Хүчиндэх
5	13.4 дүгээр зүйл	Хүнийг хууль бусаар хорих, хүчээр алга болгох	12.3 дугаар зүйл	Бэлгийн мөлжлөг
6	17.2 дугаар зүйл	Дээрэмдэх	13.1 дүгээр зүйл	Хүн худалдаалах
7	19.3 дугаар зүйл	Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах	13.2 дугаар зүйл	Хүн хулгайлах
8	21.12 дугаар зүйл	Эрүү шүүлт тулгах	13.3 дугаар зүйл	Хүн барьцаалах
9	29.1 дүгээр зүйл	Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх	13.4 дүгээр зүйл	Хүнийг хүчээр алга болгох
10	29.8 дугаар зүйл	Террор үйлдэх	15.3 дугаар зүйл	Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах
11	-	-	15.5 дугаар зүйл	Хууль бусаар үр хөндөх
12	-	-	16.1 дүгээр зүйл	Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах
13	-	-	16.3 дугаар зүйл	Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх
14	-	-	16.6 дугаар зүйл	Хүүхэд худалдах
15	-	-	16.7 дугаар зүйл	Хүүхэдтэй хэрцгий харьцах
16	-	-	16.11 дүгээр зүйл	Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх
17	-	-	17.2 дугаар зүйл	Дээрэмдэх

18	-	-	19.3 дугаар зүйл	Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах
19	-	-	21.12 дугаар зүйл	Эрүү шүүлт тулгах
20	-	-	29.1 дүгээр зүйл	Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх
21	-	-	29.8 дугаар зүйл	Террорист үйлдэл хийх

Гэхдээ уг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл /Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дараах хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж ялгамжтай байхаар хуульчилжээ.

Дээрх хуулийн заалтуудыг судалж үзвэл хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэж үйлдсэн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгож байхаар хуульчилсан байна гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах гол үзэл баримтлал болохыг дээр дурдсан.

Үүнд гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд шууд учирсан хохирлыг хамааруулан ойлгох шаардлагатай.


Иймд гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирч буй хохирлын хэмжээг тодорхойлсноор дээрх чиг үүргээ төр хэрхэн хангаж байгаад дүгнэлт хийхэд нөлөөлнө гэж үзэж байна.

Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, шүүхээс шийтгүүлсэн гэмт хэргийн тоон мэдээг 2017, 2018, 2019 оны байдлаар авч үзсэн болно.

2017 онд Улсын хэмжээнд нийт 32259 гэмт хэрэг бүртгэгдсэн ба 2018 онд 36220 гэмт хэрэг, 2019 онд 31524 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна[6].

Үүнээс 2017 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс нийт 10412 хэргийг, 2018 онд 14207 хэргийг, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 11577 хэргийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн байна[7].

Зураг 1. Улсын хэмжээнд тухайн жилд бүртгэгдсэн болон шүүхээр шийтгүүлсэн гэмт хэргийн дүн.



Мөн онуудад бүртгэгдсэн болон шүүхээр таслан шийдвэрлэгдсэн хэргийн тоонд хамаарах тухайн онд улсад болон хувийн өмч буюу иргэнд учирсан хохирлыг хэмжээг мөнгөн дүгнээр илэрхийлснийг харьцуулан үзэх шаардлагатай.

2017 оны байдлаар улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас 198.073.2 сая төгрөгийн хохирол учирсан бол 2018 онд гэмт хэргийн улмаас 193.315 сая төгрөг[8], 2019 онд 162.346.6 төгрөгийн хохирол учирсан байна[9].

Зураг 2. Гэмт хэргийн улмаас улсад учирсан хохирлын дүн /хэмжих нэгж сая. төг/


---

[6] Улсын хэмжээнд 2017, 2018, 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ. Цагаагийн ерөнхий газрын цахим хуудас. // https://www.police.gov.mn/tailan/

[7] Монгол Улсын шүүхийн 2017, 2018, 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн статистик. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. // https://www.judcoincil.mn/statistic/

[8] 2017, 2018 оны статистик. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn

[9] Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Статистик мэдээ. Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас. // https://www.police.gov.mn/tailan/




Сүүлийн 3 жилийн байдлаар гэмт хэргийн хохирол буурч буй нь эерэг хэдий ч төр чиг үүргийнхээ хүрээнд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг барагдуулах үүрэг тооны өсөлт, бууралтаас үл хамаарах зайлшгүй үүрэг мөн.

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд 2017 онд 186.593.5 сая төгрөг, 2018 онд 169.965 сая төгрөг, 2019 онд 155.067.7 сая төгрөгийн хохирол учирсан тухай статистик мэдээ бий[10].

Эдгээр нь улсын хэмжээнд учирсан хохирлын дийлэнх хувийг эзэлж байгаа ба гэмт хэргийн улмаас иргэд олон зуун тэрбум төгрөгийн хохирол хүлээж байгаад төр анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тулгарсныг харуулж байгаа хэрэг.

Зураг 3. Улсын хэмжээнд учирсан хохирол, иргэнд учирсан хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/



	2017	2018	2019
Улсад	198073.2	193315	162346.6
Иргэнд	186593.5	169965	155067.7

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

1. Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх, арилгах, сэргээн эдлүүлэх нь төрийн чиг үүрэг тул энэ төрлийн эрх зүйн зохицуулалт, орчныг боловсронгуй болгох;

2. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, эрх зүйн актуудын зохицуулалтын цар хүрээг тодорхойлж дүгнэх, шинэ эрх зүйн зохицуулалтад тусгах санал зөвлөмжийг боловсруулах;

[10]2017, 2018, 2019 оны статистик. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 1212.mn

3. Хуулийн хүрээнд илүү тодорхой байдлаар зохицуулах, иргэдийн эрхийг хангаж, хамгаалах хүчин чадал бүхий эрх зүйн зохицуулалтыг бий болгоход шаардлагатай судалгааг хийх;

4. Албан тушаалтнууд болон иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх;

Энэ хүрээнд Олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээ, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох тайлан мэдээ, судалгаа, зөвлөмж зэргийг судалж үзсэн болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох:

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө нь зөрчигдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг хамааруулан авч үзлээ.

Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлийн улмаас гэмт хэргийн хохирогч болсон иргэдийг хамааруулсан болно.

Гэмт хэргийн улмаас 2017 онд 37117, 2018 онд 33566, 2019 оны байдлаар 30782 иргэн тус тус хохирсон байна[11].

Энэ нь дунджаар Монгол Улсын хүн амын 1-1.2 хувь нь гэмт хэргийн хохирогч болсон төдийгүй хохирсон нэг хүнд гэмт хэргийн улмаас дунджаар 5.259.666 төгрөгийн материаллаг хохирол учирсан болохыг харуулж байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл:

Гэмт хэргийн улмаас учирч буй хохирол, түүнийг арилгах, нөхөн сэргээх асуудал нь энэ судалгааны гол үндэс суурь болж байна.

Тиймээс гэмт хэргийн улмаас бий болсон хохирлыгхэрхэн барагдуулж байгааг тодорхойлох нь зүйтэй.

2017 оны байдлаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлоос 74.508.2 сая төгрөг, 2018 онд 32.444 сая төгрөг, 2019 онд 42.759.6 сая төгрөгийг тус тус нөхөн төлсөн байна[12].

Дээрх нөхөн төлөгдсөн байдал нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээс **хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд** төлүүлсэн дүн болохыг анхаарах хэрэгтэй.

Үүнээс үлдсэн гэмт хэргийн хохирлын хэмжээ нь төрөөс гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөх хэрэгцээг тодорхойлж байна.

---


[11] Улсын хэмжээнд 2017, 2018, 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас. // https://www.police.gov.mn/tailan/

[12] Улсын хэмжээнд 2017, 2018, 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээ. Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас6// https://www.police.gov.mn/tailan/

Зураг 4. Нийт учирсан хохирлын дүн болон нөхөн төлөгдсөн хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/



Зураг 5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд барагдуулсан хувь



Энэхүү үзүүлэлтээс харахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт этгээд бусдад учруулсан хохирлоо барагдуулах ажиллагаа 2017 онд 37.6 хувь, 2018 онд 16.8 хувь, 2019 онд 27 хувь байгаа ньхангалтгүй гэж дүгнэж болохоор байна.

Шигтгээ 1.

Гэмт хэргийн улмаас хохирсон 400 хохирогчоос анкетын аргаар авсан “Та гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн авч чадсан уу?” гэсэн асуулгад судалгаанд оролцогчдын96 буюу 24 хувь нь “Тийм”, 304 оролцогч буюу 76 хувь нь “Үгүй” гэж тус тус хариулжээ.

Харин Цагдаагийн байгууллагын 100 мөрдөгчөөс мөн аргаар авсан судалгааны “Хохирогч нар гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо бүрэн авч чадсан уу?” гэсэн асуулгад нийт судалгаанд оролцогчдын 20 буюу 20 хувь нь “Тийм”, 80 оролцогч буюу 80 хувь нь “Үгүй” гэж тус тус хариулжээ.

Үүнээс дүгнэж үзвэл гэмт хэргийн улмаас хохирсон иргэд хохирлоо бүрэн гүйцэд авч чадахгүй байгаа нь төрөөс хүний эрхийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах заалт хэрэгжихгүй, хүний зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхол нөхөн сэргээгдэж чадахгүй байгааг нотолж байна.

Гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн төлж байгаа үйл ажиллагааны талаар:

Манай улсад гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох зохицуулалт бий хэдий ч түүний үйлчлэл, нөөц боломж нь хомс байдаг.

Эрх зүйн зохицуулалтын хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр заасан байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө;
2. Хандив, тусламж;
3. Шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;
4. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөрөөс бүрдэж байна.

Хууль хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам[13]”-ыг батлан гаргаж, 2018 оны 143 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай тогтоол[14]”-оор өөрчлөн найруулсан.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох санд 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 6.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө төвлөрсөн бөгөөд Засгийн газрын 132 дугаар тогтоол батлан гарсанаас хойш буюу 2012-2019 оны хооронд 18 удаагийн тушаалаар нийт 305 хохирогчид 1.285.274.685 төгрөгийн нөхөн олговорыг “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гаас олгосон[15] байна.

Хүснэгт 2.

№	ХЗДХСайдын тушаал		Сангаас олгосон		Дүүсгавар болсон г/х	Санд төвлөрүүлсэн	Санд буцаан төвлөрүүлэх үлдэгдэл
	Огноо	Дугаар	Төлбөр авагчийн тоо	Хохирлын мөнгөн дүн			
1	2012.11.02	А/59	1	2,882,500	-	902,336	1,980,164
2	2013.05.03	А/96	7	18,748,370	3	6,389,623	12,358,747
3	2013.09.04	А/188	8	29,852,444	6	24,050,994	5,801,450
4	2013.12.09	А/253	9	19,708,903	3	5,523,012	14,185,891

[13] Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам// https://www.legalinfo.mn/annex/details/2868?lawid=7514

[14]Журамд өөрчлөлт оруулах тухай тогтоол // https://www.legalinfo.mn/law/details/13404


[15]ШШГЕГ-ын 12 дугаар сарын тайлан, мэдээ

5	2014.03.13	А/18	14	49,195,813	9	31,462,805	17,733,008
6	2014.12.23	А/240	47	196,005,476	17	55,505,602	140,499,874
7	2015.03.24	А/67	14	45,984,810	9	26,202,281	19,782,529
8	2015.07.03	А/146	21	68,220,655	11	28,588,849	39,631,806
9	2015.11.24	А/264	17	62,341,018	3	17,855,300	44,485,718
10	2016.04.08	А/103	16	51,275,822	6	17,974,975	33,300,847
11	2016.08.23	А/23	23	103,112,966	3	12,027,068	91,085,898
12	2016.12.12	А/113	21	80,350,028	9	29,875,548	50,4744,480
13	2017.04.18	А/91	18	76,491,984	4	16,557,780	59,934,204
14	2017.11.30	А/281	21	96,583,889	4	21,391,859	75,192,030
15	2018.04.27	А/81	16	87,510,740	1	11,069,142	76,441,598
16	2018.05.25	А/102	3	19,314,620	-	-	19,314,620
17	2018.10.04	А/189	12	53,789,565	2	5,780,849	48,008,716
18	2019.09.06	А/173	18	97,222,571	-	2,991,374	94,231,197
19	2019.12.09	А/228	19	126682511			
Нийт дүн			**305**	**1.285.274.685**	**90**	**314,149,397**	**1.298.712.777**

Тус сангаас сүүлийн 3 жилийн байдлаар нийт 107 төлбөр авагчид 557.5 сая төгрөгийн нөхөн олговор олгосон байна. Энэ нь дундажаар нэг төлбөр авагч 5.210.280 төгрөгийн нөхөн төлбөр авсан үзүүлэлт юм.

Дээрх нөхөн олговрийг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээтэй харьцуулж үзвэл тун хангалтгүй болох нь илэрхий юм.

Зураг 6. Нийт учирсан хохирлын дүн болон нөхөн төлөгдсөн хохирлын дүн /хэмжих нэгж сая.төг/



Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Засгийн газрын тусгай сангаас гэмт хэргийн улмаас хохирсон зарим иргэдэд нөхөн төлбөр олгож байгаа хэдий ч нийт гэмт хэргийн улмаас учирсан

хохиролтойхарьцуулахадтүүний нэг хувьд ч хүрэхгүй үзүүлэлт харагдаж байна.

Шигтээ 2.

Судалгаанд хамрагдсан Цагдаагийн байгууллагын 100 мөрдөгчөөс анкетын аргаар авсан “Та гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан байдаг гэдгийг мэдэх үү?” асуулгад нийт оролцогчдын 70 буюу 70 хувь нь “Мэдэхгүй”, 30 буюу 30 хувь нь “Мэднэ” гэж хариулсан бол гэмт хэргийн улмаас хохирсон 400 иргэнээс мөн аргаар авсан дээрх асуулгад нийт ороцсон иргэдийн 344 буюу 86 хувь нь “Мэдэхгүй”, 56 буюу 14 хувь нь “Мэднэ” гэж тус тус хариулсан.

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг барагдуулах ажиллагаанд албан тушаалтан болон иргэдийн хохирлоо хэрхэн нөхөн төлүүлэх талаар эрх зүйн мэдлэг дутмаг байгааг харуулж байна.

Нөгөө талаас Засгийн газрын тусгай сангаас гэмт хэргийн улмаас хохирсон төлбөр авагчид нөхөн төлбөр олгохдоо зөвхөн хөдөлмөрийн чадваргүй гэмт этгээд, ялтан, хоригдлын үйлдсэн гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг гаргуулж байгаа нь гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тогтолцоо хангалттай бүрдээгүй болохыг тодорхойлж байна.

Санд буцаан төвлөрүүлэх ажиллагааны талаар:

“Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ын 7.1-д “Сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасны дагуу санд буцаан төвлөрүүлэхээр заасан.

Нийт 294 төлбөр төлөгч хоригдолд холбогдох 1.158.592.174 төгрөгийг эргэн төвлөрүүлэхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар 314.149.397 төгрөгийг зохих санд буцаан төвлөрүүлж, үүнээс 90 төлбөр төлөгчид холбогдох гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгожээ. Төлбөрийн үлдэгдэлтэй 204 төлбөр төлөгчийн 165 төлбөр төлөгч хорих ял эдэлж байна. Эргэн төвлөрүүлэлтийн биелэлт 27.1 хувьтай байна.

Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй иргэнд олгох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлт нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлын нөхөн төлөлтийг улсын хэмжээнд тодорхойлох гол үзүүлэлт юм.

Хүснэгт 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2017-2019 онд гүйцэтгэсэн эрүүгийн хэргийн шийдвэртэй хохирол барагдуулах ажиллагааны гүйцэтгэлийн дүн мэдээ
/мөнгөн дүнг хэмжих нэгж сая.төг/

№	Үзүүлэлт	Нийт	Гүйцэтгэсэн	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь
2017					
1	Гүйцэтгэх хуудсын тоо	5353	2324	3029	43.3%
2	Мөнгөн дүн	**43,279.2**	**3,805.6**	**39,472.5**	**8.8%**
2018					
1	Гүйцэтгэх хуудсын тоо	5828	3569	2259	61.2%
2	Мөнгөн дүн	**48,853.2**	**9,473.5**	**39,379.6**	**19.4%**
2019					
1	Гүйцэтгэх хуудсын тоо	5948	3354	2594	56.4%
2	Мөнгөн дүн	**71,812.8**	**7,745.1**	**64,067.7**	**10.8%**

Дээрх дүн мэдээнээс үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажиллагаа гүйцэтгэх хуудасны биелэлт өндөр боловч, мөнгөн дүнгийн биелэлт бага байгаа нь гэмт хэргийн хохирлыг төрөөс нөхөн төлөх, иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээх асуудалд анхаарах шаардлага бий болсныг нотолж байна.

Гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг хэрхэн төлөгдөж байгааг тодорхойлох үүднээс гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн тоо, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүн шилжилгээ хийлээ.

2017 онд ял шийтгүүлсэн 9019 хүн, 2018 онд 12366 хүн, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар 10149 хүн байна. Үүнээс 2017, 2018 онд ял шийтгүүлэгчдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг авч үзвэл:

- Боловсролын байдлаар нь авч үзвэл 2017 онд нийт ял шийтгүүлэгчдийн 16 хувь нь дээд, 6 хувь нь суурь, 10 хувь нь бага, 21 хувь нь боловсролгүй, 42 хувь нь бүрэн дунд, 5 хувь нь тусгай дунд болон бусад боловсролтой хүмүүс байна.


2018 онд 17.7 хувь нь дээд, 17.7 хувь нь суурь, 8.8 хувь нь бага, 5.9 хувь нь боловсролгүй, 44.3 хувь нь бүрэн дунд, 5.7 хувь нь тусгай дунд болон бусад боловсролтой хүмүүс байна.

- 2017 онд хөдөлмөр эрхлэлтийн хувьд төрийн албанд 3.3 хувь, 23.9 хувийн хэвшлийн байгууллагад 2.5 хувь нь сурагч, 3.1 хувь нь оюутан, 4.9 хувь нь оюутан, 61.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс эзэлж байна.

2018 онд ял шийтгүүлэгчдийн 5.6 хувь нь төрийн албанд, 36.8 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад, 1.9 хувь нь сурагч, 9.5 хувь нь малчин, 68.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс байна.

Дээрх судалгаанаас харахад 2017, 2018 онд шүүхээр ял шийтгүүлсэн хүмүүсийн олонхи нь бүрэн дунд боловсролтой, мөн боловсролгүй иргэд байна.

Зураг 7. Ял шийтгүүлсэн хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



Дээрх судалгаанаас дүгнэжүзвэл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүмүүсийн 60-аас илүү хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй байгаа нь өөрийн үйлдсэн гэмт хэргийн улмаас иргэнд учруулсан хохирлоо тухай бүр нөхөн төлөх чадвар төдийлөн хангалттай бус болохыг илэрхийлж байна.

Шигтгээ 3.

Засгийн газрын тусгайн сангийн тухай хуульд тусгасан 21 төрлийн гэмт хэргээс бусад хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэгдсэн хэргийн хохирогчдын хохирлыг хэрхэх вэ гэдэг асуудал тулгараад байна.

Нэгэн жишээ дурдвал: Хүний амь нас хохироогүй атлаа зөвхөн мөнгөн хөрөнгөө нэр бүхий 26 хадгаламж зээлийн хоршоонд хадгалуулсан хадгаламж эзэмшигч нарыг хохирлыг 2007 онд Улсын Их Хурлаас“Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай” хууль баталж, 33.0 тэрбум төгрөгийг хадгаламж эзэмшигч нарт олгосон байдаг. Түүнчлэн 2014 онд УИХурлаас уг хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулж, улмаар хохирлыг мөнгийг дахин улсаас олгохоор хуульчилсан байдаг.

Өөрөөр хэлбэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар дээрх гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлүүлэхээр хуульчилсан хэдий ч бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхгүйгээр орхигдуулсан нь Монгол Улсын Үндсэн


хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасантай зөрчилдөж байгааг харуулж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгасан 21 төрлийн гэмт хэрэгт мөн сангаас нөхөн төлбөр олгох талаар заасан бөгөөд тухайн төрлийн гэмт хэргийн гаралтыг бусад нийтлэг үйлдэгддэг 6 төрлийн гэмт хэргийн гаралттай харьцуулан авч үзлээ.

2019 оны байдлаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгасан гэмт хэргүүдээс нийтлэг үйлдэгдсэн тоог авч үзье. Үүнд:

- “Хүнийг алах” гэмт хэрэг197,
- “Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах” гэмт хэрэг 238,
- “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах” гэмт хэрэг 319,
- “Хүчиндэх” гэмт хэрэг 481,
- “Бэлгийн мөлжлөг” гэмт хэрэг 6,
- “Хүн худалдаалах” гэмт хэрэг 14,
- “Хүн хулгайлах” гэмт хэрэг 4,
- “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэрэг 3,
- Хүүхдийн эсрэг гэмт хэрэг 31,
- “Дээрэмдэх” гэмт хэрэг 868 удаабуюу нийт 2161 гэмт хэрэг байна.

Зураг 10. ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд тусгасан гэмт хэргийн 2019 онд үйлдэгдсэн байдал




Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 21 төрлийн гэмт хэрэг нь нийт 2161 буюу улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 6.8 хувийг

эзэлж байгаа нь гэмт хэргийн улмаас иргэнд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах өнөөгийн орчныг илэрхийлж байна.

Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд шууд хор уршиг, хохирол учруулдаг боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгаагүй 59 төрлийн гэмт хэрэг байна. Үүнээс нийтлэг үйлдэгпэж буй 6 төрлийн гэмт хэргийг тусгайлан авч үзлээ. Үүнд:

- “хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх” гэмт хэрэг 104,
- “хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах” гэмт хэрэг 7394,
- “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг 207,
- “заналхийлэх” гэмт хэрэг 53,
- “хулгайлах” гэмт хэрэг 8968,
- “залилах” гэмт хэрэг 4688 удаа буюу нийт 21414 удаа гэмт бүртгэгдсэн байна.

Зураг 11. Эрүүгийн хуульд заасан 59 төрлийн гэмт хэргээс зонхилон үйлдэгдэж буй 6 гэмт хэргийн 2019 онд бүртгэгдсэн байдал



Энэ нь 2019 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 68.2 хувийг эзэлж байна.

Шигтгээ 4.

Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн улмаас хохирсон 400 хохирогчоос анкетын аргаар авсан “Та ямар гэмт хэргийн хохирогч болж байсан бэ?” гэсэн асуултад давхардсан тоогоор 8 оролцогч буюу 2 хувь нь “Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн, 8 оролцогч

буюу 2 хувь нь “Хүний бэлгийн эрх чөлөө,халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн, 40 оролцогч буюу 10 хувь нь “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийн, 160 оролцогч буюу 40 хувь нь “Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн, 184 оролцогч буюу 46 хувь нь “Хөдөлгөөний аюулгүй байдал,тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг”-ийн хохирогч тус тус болж байсан хэлж хариулжээ.

Харин Цагдаагийн байгууллагын 100 мөрдөгчөөс мөн аргаар авсан судалгааны “Таны ажил үүргээ хэрэгжүүлэх явцад ямар төрлийн гэмт хэргийн хохирогч дийлэнхи тохиолдолд хандаж байна вэ? /Гурваас доошгүйг дугуйлна уу/” гэсэн асуулгад давхардсан тоогоор нийт оролцогчдын 8 буюу 8 хувь нь “Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг”-ийн, 44 оролцогч буюу 44 хувь нь “Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн, 26 оролцогч буюу 26 хувь нь “Хүний бэлгийн эрх чөлөөтэй байх эрхийн гэмт хэрэг”-ийн, 2 оролцогч буюу 2 хувь нь “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн гэмт хэрэг”-ийн, 10 оролцогч буюу 10 хувь нь “Хүний хувийн, улс төрийн эрх, чөлөөний эсрэг гэмт хэрэг”-ийн, 14 оролцогч буюу 14 хувь нь “Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-ийн, 16 оролцогч буюу 16 хувь нь “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг”-ийн гэж тус тус хариулжээ.

Судалгаанаас харахад хүний “халдашгүй байдлын эсрэг”, “эрүүл мэндийн эсрэг”болон “өмчлөх эрхийн эсрэг” гэмт хэрэг зонхилон үйлдэгддэг болох нь харагдаж байна.

Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан 21 төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах эрх зүйн зохицуулалттай боловч дээрх хуульд тусгагдаагүйулсын хэмжээнд нийтлэг үйлдэгддэг 6 төрлийн гэмт хэргийн гаралтын түвшинтэй харьцуулахад 10 хувьтай тэнцэж байгаа нь гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлөх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, шинэ эрх зүйн зохицуулалт бий шаардлагатай байгааг илтгэж байна.

ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ:

Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх чиглэлийн хүрээнд өнөө үед эрх зүйн тогтолцооны хувьд дэлхий нийтэд тэргүүлэх туршлага бүхий дараах орнуудын эрх зүйн зохицуулалтыг судланавч үзлээ.

Америкийн Нэгдсэн Улсын хувьд:

Холбооны хэмжээнд 1984 батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хууль (Victims of Crime Act-VOCA) нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуульд 1988, 1993-1997, 1999-2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Уг хуулиар гэмт хэргийн хохирогчийн сан байгуулах, санг бүрдүүлэх, санхүүжүүлэх, хуваарилах, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох зардал, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл, олгох журам, уг ажлыг зохион байгуулах зэрэг асуудлыг хуульчилсан байна.

Энэхүү хуульд зааснаар Холбооны хэмжээнд АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчийн алба нь тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, сангийн мөнгөн хөрөнгийг хуваарилах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг хариуцан ажилладаг ажээ.

АНУ-ын 50 мужид гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийг батлан гаргасан бөгөөд муж бүр тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Гэмт хэргийн хохирогчийн тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн хохирогчийн сангаас мужуудын хөтөлбөрийг санхүүгийн эх үүсвэрээр хангаж байна. 1884 онд батлагдсан Гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд АНУ-ын хэмжээнд гэмт хэргийн хохирогчийн тухай хуулийн дагуу муж бүр гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийн хамт уг асуудалтай холбогдсон зүйлтэй нийтлэг дараах эрх зүйн зохицуулалт байна.

АНУ-ын муж бүрт гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн тусламж үзүүлж байна. АНУ-ын Хууль зүйн яам нь Гэмт хэргийн хохирогчийн албаар дамжуулан дээрх хуулийн дагуу хөтөлбөрийн санхүүжилт болон техникийн туслалцааг муж бүрт үзүүлж байдаг байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд:

ХБНГУлс нь Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулийг 1976 онд батлан гаргаж, хүчин төгөлдөр мөрдөж байгаа бөгөөд нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгодог байна.

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хуулиар нөхөн төлбөр авахад тавигдах хууль зүйн үндэслэл, гомдол гаргах, шийдвэрлэх журам, нөхөн төлбөр олгохгүй байх үндэслэл, нөхөн төлбөр олгох зардал, гэмт хэргийн хохирогчид үзүүлэх тусламж, санхүүжүүлэх зэрэг нийтлэг асуудлыг зохицуулсан байна.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын хувьд:

ИБУИНВУлсад гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрийн тухай хуулийг (Criminal Injuries Compensation Act 1995) 1995 онд батлан гаргасан бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөр хэрэгжүүлдэг байна. Уг хөтөлбөрийн дагуу хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээд санхүүгийн нөхөн төлбөр олгодог байна.

Тухайн хуульд заасны дагуу нөхөн төлбөр олгох хөтөлбөрийг төрийн бие даасан байгууллага хэрэгжүүлдэг, хөтөлбөрийн зорилго нь хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээдэд санхүүгийн нөхөн төлбөр олгоход оршино. Хөтөлбөрт зааснаар хохирогч нь эрүүл мэндийн талаасаа өвчтэй байх, гэмтлийн нөхцөлийг анагаах ухааны хувьд тодорхойлсон байх ёстой.

Япон улсын хувьд:

Япон улсын гэмт хэргийн хохирогчид төлбөр олгох тухай хууль нь 1980 онд батлагдсан бөгөөд харин одоо уг хуулийг Санхүүгийн болон бусад туслалцаа үзүүлэх тухай хууль гэж нэрлэх болсон байна. Япон улс нь гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох хөтөлбөртэй бөгөөд гэмт хэргийн улмаас хохирсон этгээд санхүүгийн нөхөн төлбөр олгодог.

Японд Үндэсний нийтийн хамгаалах газрын Гэмт хэргийн хохирогчийн алба гэх байгууллага гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох ажлыг эрхлэн явуулдаг байна. Мөн Үндэсний цагдаагийн байгууллага нь уг ажлыг хариуцан ажиллаж байна.

Оросын Холбооны Улсын хувьд:

ОХУ нь 2004 онд хохирогч, гэрч болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдын төрийн хамгаалалтын тухай хуулийг батлан гаргаж, 2005 оны 1 дүгээр сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөж байна. 2006 оноос эхлэн Засгийн газраас хөтөлбөр хэрэгжүүлж байна.

ОХУ нь Хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр хөтөлбөр заасан байна.

Судалсан орнуудын хувьд “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах” бие даасан хууль батлан мөрддөг. Мөн үүний зэрэгцээ Хохирлыг нөхөн барагдуулах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг ажээ. Эдгээр орнуудын хувьд “Хохирол нөхөн барагдуулах тухай” бие даасан хуультай боловч энэхүү хууль нь зөвхөн “Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас хохирсон этгээд”-д үйлчилдэг онцлогтой байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.*” гэсэн заалтыг нэг мөр ойлгож, хуулийг зөв хэрэглэх нь зүйтэй;

Эрх зүйн тогтолцооны хувьд хөгжингүй орнууд болох АНУ, ХБНГУ, ИБУИНВУ, ОХУ, Япон Улсын туршлагыг судалж, энэхүү харилцааг Монгол Улсын нөхцөл байдалд уялдуулан, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн, үргэлжлүүлэн эдлүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байгаа тул бие даасан хуулиар нэг мөр зохицуулах;

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тогтолцоог бүрдүүлэхийн тулд бие даасан хуулийн төсөл боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох нь зүйтэй гэж үзэж байна.

Тус хуулиар дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

-Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд хохирол учруулдаг гэмт хэргийн хохирогчдын хохирлыг төрөөс урьдчилан гаргуулах талаар хуулийн зохицуулалтыг нарийвчлан тусгах;

- Гэмт хэргийн хохирогчдын эдийн засаг, нийгмийн байдлаас үл шалтгаалан ялгаварлахгүйгээр хохирлыг төрөөс нөхөн олгох талаар зохицуулалтыг тусгах;

- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдийн засаг, нийгмийн байдлаас үл шалтгаалан хохирогчдын хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаар хуулийн зохиулалтыг нарийвчлан тусгах;

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах тусгай сангийн орлогыг хэрхэн бүрдүүлэх, сангаас гаргасан төлбөрийг хэрхэн гэмт этгээдээс буцаан авч нөхөх байршуулах талаар зохицуулалтыг зайлшгүй тусгах;

- Хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хүрээнд холбогдох зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудын зүйл, заалтуудтай нийцүүлэх зэрэг болно.

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛЖ БУЙ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
/2015-2020 судалгааны тайлангаас/



М.ХҮРЭЛБАТ
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн ахлах ажилтан-багш, хошууч

Товч агуулга: Монгол Улсын хэмжээнд хорих байгууллагуудын хэмжээнд явуулж буй нийгэмшүүлэх ажлын тайлан,судалгаанд нэгдсэн болон хэсэгчилсэн дүгнэлт хийсэн болно.

Abstract: A report on the socialization of prisons in Mongolia and a summary of the survey.

Түлхүүр үг: Үийгмийн ажил, нийгэмшүүлэх ажил, сургалт, хөтөлбөр

Key word: social work, socialization, training and programs

Манай улсын хувьд хорих байгууллага дахь “нийгмийн ажил”, “нийгэмшүүлэх” гэсэн нэр томьёо, ойлголт 2017 онд шинээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /ШШГТХ/ батлагдах хүртэл “салбарын хуульд тусгаагүй” бөгөөд “хорих байгууллага дахь нийгмийн ажил”, “нийгмийн ажилтан” гэсэн бие даасан ажил, мэргэжлийн ойлголт 2003 оноос л манай оронд бүрэлдэн бий болсон байна[1].

Харин XIX зууны сүүлчээр барууны зарим орнуудад “Forensic social work буюу шүүхийн нийгмийн ажилтнууд” гэсэн ойлголт бий болж шүүхийн төдийгүй хууль зүйн салбарт хүчтэй түрэн орж ирсэн. Ийнхүү хууль зүйн салбарт нийгмийн ажил гэсэн нэр томъёо, үйлчилгээ нэвтэрч эхэлсэн үеэс их сургууль төгссөн нийгмийн ажилтнууд пароул (parole office) болон пробацын (probation office) алба, хорих байгууллагад орж ажиллах болжээ[2]. Манай хөрш Оросын холбооны улсын хувьд ОХУ-ын Хууль зүйн сайдын 2000 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 41 дүгээр тушаалаар бүх төрлийн хорих байгууллага, урьдчилан хорих байр болон

[1] ШШГЕГ-аас 2003 онд зохион байгуулсан төв, орон нутгийн хорих ангийн дарга, ахуй дэглэмийн байцаагч нарын нэгдсэн зөвөлгөөнөөс “нийгмийн ажилтан” гэсэн нэр томьёог хэрэглэхээр тогтсон.

[2] Robert L. Barker, Douglas M. Branson. Forensic Social Work. Legal Aspects of Professional Practice, 1993. The Haworth Press, Inc., Binghamton, NY. p 2-3

тэдгээрийн салбар нэгжийн бүтэц орон тоог баталсан бөгөөд “хүмүүжлийн ажлын хэлтэс” гэсэн нэрийг “нийгэм-сэтгэл зүйн хэлтэс” хэмээн өөрчилж хорих байгууллагын бүтцэд хамааруулжээ. Ийнхүү ОХУ-ын хорих байгууллагад анх удаа хоригдолтой ажиллах мэргэжлийн нийгмийн ажлын алба байгуулагдсан[3] түүхтэй.

Бусад улсын туршлагаас үзэхэд хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө боловсруулж, тэднийг нийгэмшүүлэхэд чиглэсэн олон хууль, эрхийн акт, хөтөлбөрүүд хэрэгжүүлж ихээхэн туршлага хуримтлуулж байна.

Манай улсын хорих байгууллага дахь нийгмийн ажлын агуулга, зохион байгууллалт, эрх зүйн орчин, үйл ажиллагааг олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн бүрэлдүүлэхэд бусад орны энэ талаар хуримтлуулсан арвин туршлага, алдаа онооноос суралцах нь зохистой юм.

Өнөөгийн байдлаар хоригдогчийг нийгэмшүүлэх чиглэлээр зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хязгаарлахгүйгээр хорих байгууллагаас суллагдсан хүнд тавих хяналт, бусад чиглэлээр холбогдох хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Тухайлбал,

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2-т хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг ажилтан, ажил олгогч тус бүрд нь нэг удаа олгох, 15.1.5-т хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон *хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж*, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.

2.Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5-т Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно: 13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн;

3. *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын*

44 дүгээр зүйл. Зан үйлд нөлөөлөх сургалт

44.1. Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байна.

44.2. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр

[3] С.А.Лузгин, М.И. Кузнецов, В.Н. Казанцев, Хорих байгууллагын нийгмийн ажил: Сургалтын гарын авлага. Орос хэлнээс орчуулсан Д.Шатарбал. УБ. 2009 он., 89 дэх тал.

магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.

44.3. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

44.4. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.

44.5. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлэх

9.1. Тодорхой этгээд гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх, түүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн чиглэл гэнэ.

9.2.2. гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлж суллагдсан хүнд хяналт тавих;

9.2.3. гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял шийтгүүлж, суллагдсан этгээдэд нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх;

9.2.4. хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тодорхой үүрэг хүлээлгэсэн, хориглолт, хязгаарлалт тогтоосон хүнд хяналт тавих;

9.2.5. гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох;

9.2.6. энэ хуулийн 12.1.5, 12.1.6-д заасан хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт, шалгалт хийх, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх;

41 дүгээр зүйл. Хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тогтоох

41.1.Эрүүгийн хуулийн 10.1, 11.2, 12.1, 12.3, 15.1, 15.5, 15.6, 16.2, 17.1, 18.6, 19.2, 19.5, 19.6, 19.8, 20.3, 20.7, 20.8, 26.1, 26.2, 26.3, 29.8, 29.10 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж суллагдсан болон хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял эдэлж, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хяналтын хугацаа нь дууссан хүнд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт тогтооно.

41.2. Энэ хуулийн 41.1-д заасан хяналтыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, түүний алба хаагч гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд цагдаагийн төв байгууллагын шийдвэрээр үйлдсэн гэмт хэргийн төрлөөс хамааран тухайн төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг дагнан хэрэгжүүлж байгаа цагдаагийн байгууллагын нэгж, алба хаагчид даалгаж болно.

41.3. Хяналтад байгаа хүний хяналтын хугацаа дууссан бол уг хяналтыг тавьж байгаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтыг дуусгавар болгоно.

41.4. Энэ хуулийн 41.1-д заасан хүн хорих ял эдлэн суллагдаж, эсхүл чөлөөлөгдөж байнга оршин суух газартаа очсоноос хойш долоо хоногийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

41.5. Хорих байгууллага хорих ял эдэлж байгаа хүнийг суллагдахаас 30 хоногийн өмнө, хяналт тавьж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.6 дугаар зүйлд заасан хяналтын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө, Эрүүгийн хуулийн 6.12, 6.13, 6.14 дүгээр зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн даруй тус тус байнга оршин суух газрын цагдаагийн байгууллагад түүний суллагдах тухай мэдэгдлийг зохих тодорхойлолтын хамт хүргүүлнэ.

42 дугаар зүйл. Хяналт тавих хугацаа

42.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хяналтыг энэ хуулийн 41.1-д заасан хүнд оногдуулсан хорих ялын хугацаатай уялдуулан нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр нэгээс гурван жил хүртэл хугацаагаар тогтооно.

42.2. Хяналтад байгаа хүн урьд өмнө хяналтад байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн бол хяналтын хугацаа нь энэ хуулийн 42.1-д заасан хугацаан дээр хоёр жилийн хугацааг нэмж тогтооно.

42.3.Хяналтад байгаа хүн хяналтаас зайлсхийсэн /хуульд заасны дагуу бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн боловч гурван сар, түүнээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй/, оргон зайлсан /хуульд заасны дагуу бүртгүүлээгүй, эсхүл бүртгүүлсэн боловч зургаан сар, түүнээс дээш хугацаагаар цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй/, эсхүл энэ хуулийн 43.1-д заасан үүргээ удаа дараа /3 ба түүнээс дээш удаа/ биелүүлээгүй бол энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр хяналтын хугацааг тухай бүр зургаан сарын хугацаагаар сунгаж тогтооно.

42.4. Хяналтад байгаа хүн гэмт хэрэг дахин үйлдэж болзошгүй хангалттай үндэслэл байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдэн эрүүгийн

хэрэгт яллагдагчаар татагдан шалгагдаж байгаа тохиолдолд энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр тухайн үндэслэл арилах хүртэл хугацаагаар хяналтын хугацааг сунгаж болно.

42.5. Хяналтад байгаа хүн хуульд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа бөгөөд ажил хөдөлмөр эрхлэлт, зан төлөвийн хувьд засарч нийгэмд бүрэн дасан зохицсон, цаашид гэмт хэрэг үйлдэхгүй гэх хангалттай үндэслэл тогтоогдсон, эсхүл гадаад улсад удаан хугацаагаар зорчих бол энэ хуулийн 42.1-д заасан албан тушаалтны шийдвэрээр хугацаанаас өмнө хяналтыг дуусгавар болгож болно.

42.6. Энэ хуулийн 42.2, 42.3, 42.4-т заасны дагуу хяналтын хугацааг сунгасан бол хяналт тавих нийт хугацаа нь тухайн хүний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулахаар Эрүүгийн хуульд заасан хорих ялын дээд хугацаанаас хэтэрч болохгүй.

42.7. Хяналтын хувийн хэргийн загвар, хугацааг тогтоох жишгийг цагдаагийн төв байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн тогтооно.

45 дугаар зүйл. Хяналтын хэлбэр

45.1. Хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналтын хүрээ, хяналтад ашиглах арга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хяналтад байгаа хүний үйлдсэн гэмт хэргийн төрөл, онцлог, түүний хувийн байдалд нийцүүлэн ялгамжтайгаар тогтооно.

45.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ дараах хэлбэртэй байна:

45.2.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ярилцлага хийх, зөвлөгөө өгөх;

45.2.2. хяналтад байгаа хүнийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

45.2.3. ял шийтгүүлсэн гэмт хэргийн төрөл, хувийн байдлаас хамааран урьд өмнө гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэсэн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар тодорхой үүрэг өгч, биелэлтийг хангуулах;

45.2.4. хяналтад байгаа хүний зан үйл, хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны талаар тусгайлсан шаардлага, хориглолт, хязгаарлалт тогтоох;

45.2.5. ажил хөдөлмөр эрхлэлтийн байдал, үйл ажиллагааг нь биечлэн шалгах;

45.2.6. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэж тэнсэн харгалзсан этгээд мансууруулах эм, бодис хэрэглэсэн эсэхийг тодорхой цаг хугацааны давтамжтайгаар шалгах;

45.2.7. хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай

албадлагын арга хэмжээг авах, захиргааны журмаар албадан эмчилгээнд хамруулах.

45.3. Хяналтад байгаа хүн энэ хуулийн 42.1-д заасны дагуу тогтоосон хугацааны эхний хагаст зан байдлаараа нийтэд аюулгүй болсон гэдгээ нотлон харуулсан бөгөөд цаашид тогтмол хяналт тавих шаардлагагүй бол хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хяналтын үлдсэн хугацаанд энэ хуульд заасан хяналтын түвшинг хөнгөрүүлж болно.

45.4. Энэ хуулийн 45.2-т заасан хяналтад байгаа хүний эерэг зан, төлөв байдлаас хамааран урамшуулах буюу цагдаагийн байгууллага, алба хаагч хяналтад байгаа хүнийг зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад дуудахгүй байх, энэ хуулийн 43.1.2, 43.1.4, 43.1.5-д заасан хугацаа, давтамжийг хуульд зааснаар сунгаж тогтоох болон урьд тогтоосон зарим үүрэг, хориглолт, хязгаарлалтыг цуцлах байдлаар хэрэгжүүлнэ.

45.5. Хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагыг сайн дурын үндсэн дээр оролцуулж болно.

2017 онд шинээр баталсан ШШГТХ-д анх удаа нийгэмшүүлэх ажил, нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт гэсэн тусгай зохицуулалт тусгагдсан. Тухайлбал уг хуулийн 218 дугаар зүйлийн 218.1-д “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ”, 219 дүгээр зүйлийн 219.1-д “Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна” гэжээ.

Хүснэгт 1. 2002, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийгэмшүүлэх ажлын талаар туссан байдалд хийсэн харьцуулалт

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	**2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль**
Хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: -ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; -насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох;	Хорих анги дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: -хоригдолд хүмүүжлийн нөлөө үзүүлэх; -хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох;

-ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгох…	-хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг ерөнхий боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн дадлага олгох…
Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт 1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна. 2.Хүмүүжлийн ажилд хорих байгууллагын ажилтнуудаас гадна шашны, буяны болон бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно. 3.Ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно.	**Нийгэмшүүлэх ажил** 1.Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдол хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан, хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ. 2.Хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллана. 3.Хорих анги дахь нийгэмшүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтаас санхүүжүүлж болно.
	Нийгэмшүүлэх ажлын хэлбэр, зохион байгуулалт 1.Хоригдлыг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон хүсэл, сонирхолд нь үндэслэн эерэг зан үйлд төлөвшүүлэх бусад хэлбэрээр нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна. 2.Нийгэмшүүлэх ажилд хорих ангийн алба хаагчаас гадна бусад байгууллага, иргэнийг оролцуулж болно. 3.Нийгэмшүүлэх ажлыг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн болон түүний

	хувийн байдал, нас, хүйс, ял эдлүүлэх нөхцөлийг харгалзан ганцааарчилсан, бүлгийн, эсхүл нийтэд чиглэсэн хэлбэрээр тусгай хөтөлбөр боловсруулж үе шаттай, ялгамжтай зохион байгуулна. Нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад хорих анги, алба хаагч, бусад байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд туслалцаа авч болно. 4.Хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөр, сургалттай хослуулах, хоригдлын бүтээлч ажиллагаа, үр ашигтай санаачилгыг дэмжих, ёс зүй, сэтгэл зүйн нөлөөллийг хорих ангийн дэглэм, зэрэглэлийн онцлогийг харгалзан зохион байгуулна.
Хорих анги дахь сургалт 1.Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ. 2.Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна. 3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. 4.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна.	**Хорих анги дахь сургалт** 1.Өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад хоригдолд бие даан мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэхэд нь хорих анги туслалцаа үзүүлнэ. 2.Ерөнхий боловсролын сургалтыг хорих ангийн байранд зохион байгуулна.
	Хорих анги дахь сургалтын хэлбэр 1.Хорих анги өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно. 2.Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад хоригдлыг сайн дурын үндсэн дээр хамруулна.
	Хорих анги дахь албадан сургалт
	Хорих анги нь монгол хэлээр уншиж, бичиж чадахгүй Монгол Улсын иргэн-хоригдолд монгол хэл, бичиг үсэг эзэмшүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг зохион байгуулна.

Хүснэгт 2. Нийгэмшүүлэх ажлын зааврын харьцуулалт

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар /2010.11.10/	Нийгмийн ажлын аргачилсан заавар /2018.7.3/
Нийгмийн ажил гэж	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажил нь хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хоригдогчийн нийгмийн харилцаанд тодорхой үүрэг, байр суурьтай оролцох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа юм.	“Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил” гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1 дэх хэсэгт зааснаар хоригдол нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход нь дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ.
Нийгмийн ажилтан гэж	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтан нь мэргэжлийн хувьд нийгмийн ажлын боловсролын бакалаврааас доошгүй зэрэгтэй эсхүл нийгмийн ажлын чиглэлээр мэргэжлийн болон давтан сургалтанд хамрагдан мэргэшсэн цэргийн албан хаагч байна.	**Нийгмийн ажилтан** гэж хорих байгууллагын нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн тусгай албан хаагчийг тус тус ойлгоно.
Хорих ангийн нийгмийн ажлын зохион байгуулалт, чиг үүрэг	
Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хоригдогчийг чадваржуулах, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлган нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэхэд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нараас бүрдсэн баг ажиллуулах ба мэргэжлийн бие даасан үйл ажиллагаатай байхаар зохион байгуулна.	Хорих ангийн нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 1.хорих ангийн дарга, дэд дарга мэргэшсэн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана; 2.мэргэшсэн нэгж нь хоригдлын нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж хорих ангийн даргаар батлуулна; 3.нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас бүтэн жилээр, сургалтын үр дүнгийн талаарх тайланг, тоон судалгааг сар бүрийн 25-ны дотор

	хорих ангийн даргад танилцуулан, энэ зааврын 2.1-д заасан нэгжид хүргүүлнэ; Мэргэшсэн нэгж нь хоригдлын дунд явуулах сургалт, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулахад тухайн жилд шаардагдах арга хэмжээний зардлын тооцоог гаргаж, хорих ангийн даргаар уламжлуулан шийдвэрлүүлнэ.
Нийгэмшүүлэх ажлын үе шат	
1. Хоригдогчийн нийгмийн болоод сэтгэл зүйн хэрэгцээнд үндэслэн нийгмийн ажлын үйлчилгээг төлөвлөх, харилцаа холбоо тогтоох. 2. Хоригдогчид ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэлзүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх. 3 Хоригдогчийн хувийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, тэдгээрийг чадваржуулах, хувь хүний давуу тал, нөөц боломжийг нээн хөгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах. 4. Хоригдогчийн сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх. 5. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд хэрэгжүүлэх нийгмийн ажилд хоригдогчийн өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах, 6. Хоригдогчийн хуулиар хориглоогүй эрхийг хангах; 7. Хоригдогчийг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэлзүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх.	1.Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил. 2.Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил. 3.Суллагдахын өмнөх нийгэмшүүлэх ажил.
Судалгааны ажил	
Шинээр ирсэн хоригдогчийг дараах чиглэлээр судлана: 1. зан төлөв, 2. биеэ авч яваа байдал, 3. хувийн сэтгэл зүйн онцлог,	Нийгмийн ажилтан өдөр тутмын үйл ажиллагаандаа дараах бүртгэл, судалгааг гаргасан байна. 1.илгээсэн захидлын бүртгэл;

4. орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл санааны хямралд орсон эсэх, 5.хувь хүний давуу талууд буюу мэргэжил, боловсрол, спорт, урлагын болон бусад авьяас чадвар, боломжууд, 6.ар гэр, төрөл төрөгсөд, найз нөхөд буюу ойр дотны хүмүүсийн талаар, 7. ажиллаж, амьдарч байсан газар, нутаг орон, 8. урьд нь ял шийтгэл эдэлж байсан тохиолдолд тухайн үеийн ял эдлэлтийн байдал, 9. үйлдсэн гэмт хэргийн байдал. 10. сэтгэцийн эрүүл мэндийн байдал,	2.өргөдөл, гомдол, санал хүсэлтийн бүртгэл; 3.хоригдлын ар гэртэй уулзсан бүртгэл; 4.номын сангаар үйлчлүүлсэн хоригдлын бүртгэл; 5.сургалт зохион явуулсан бүртгэл; 6.хоригдолтой уулзсан бүртгэл; 7.гэмт хэрэг,нас, мэргэжил, боловсролын судалгаа; 8.хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын судалгаа; 9.хоригдлын гэр бүл, эргэлт уулзалтгүй хоригдлын судалгаа 10.суллагдахын өмнөх хугацаанд сургалтад хамрагдах хоригдлын судалгаа;

Хүснэгт 3.Сэтгэл зүйчийн үйл ажиллагааг зохицуулж ирсэн зааврын харьцуулалт

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны сэтгэл зүйчийн ажлын заавар /2010.11.10/	Сэтгэл зүйн ажлын заавар /2019.6.7/
Сэтгэл зүйч гэж:	
Сэтгэл судлалын чиглэлээр боловсролын бакалавраас доошгүй зэрэгтэй байхын зэрэгцээ мэргэшлийн шаардлагын хувьд: -Хуулийн сэтгэл судлал -Сэтгэц - оношлогоо -Хүний хөгжлийн сэтгэлзүй -Сэтгэлзүйн зөвлөгөөний онол-арга зүйн чиглэлээр бие даан мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх арга техникийг эзэмшсэн албан хаагч байна.	Хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх алба хаагчийг хэлнэ.
Сэтгэл зүйчийн үйл ажиллагаа:	
1.Хоригдогчийн сэтгэл зүйн байдлыг оношлон тодорхойлох; 2.Хоригдогчид сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх; 3.Хорих байгууллагын нийталбан хаагчдад үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх;	Хорих ангийн сэтгэл зүйч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. 1.Хоригдлоос сэтгэл зүйн судалгаа авах; 2.Хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлох; 3.Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх;

4.Сэтгэлзүйн мэргэжлийн үйлчилгээний үр дүнд хоригдогчид гарч буй өөрчлөлтийг үнэлэх; 5.Мэргэжлийн үйлчилгээний явцад гарсан санал дүгнэлтийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үндсэн чиглэлд тусгаж ажиллах; 6.Үйлдсэн гэмт хэргийн буюу гэмт хэргийн байдлаа хүлээн зөвшөөрөөгүйн улмаас сэтгэлзүйн стресс, хямралд орсон хоригдогчийг судалгааны аргаар илрүүлэн оношлон мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх; 7.Өөрийн мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт хийж, өөрийн болон мэргэжлийн хөгжилд хувь нэмэр оруулах;	4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 222.1-д зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгүүлсэн болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлын зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулна;
Сэтгэл зүйчийн үйл ажиллагааны баримтжуулалт	
Хоригдогчид зориулсан дараах маягтуудыг нээж хөтлөнө.Үүнд: 1.Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөний тэмдэглэл, 2.Холбон зуучлах хуудас, 3.Оношлогооны маягт, 4.Үнэлгээний хуудас, 5.Сэтгэл зүйн сорил түүний үр дүнгийн маягт, 6.Сэтгэл зүйчийн тодорхойлолт, 7.Сэтгэл зүйчийн үйлчилгээний цагийн хуваарь	Сэтгэл зүйч дараах тэмдэглэл,судалгааг гаргаж хоригдогчийн мэдээллийн санд баяжилт хийсэнбайна. 1.Сэтгэл зүйн зөвлөгөөний хуудас /гэрээ/; 2.Анхны ярилцлагын тэмдэглэл; 3.Уулзалтын тэмдэглэл; 4.Холбон зуучлах хуудас; 5.Хоригдогчийн гэр бүлтэй хамтран ажилласан бүртгэл; 6.Сэтгэл зүйн тодорхойлолт; 7.Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдогчийн судалгааг улирал бүр гаргах /загварын дагуу/; 8.Зөрчил гаргасан хоригдогчтой уулзсан талаарх тэмдэглэл; 9.Сэтгэл зүйн дүгнэлт; 10.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдах хоригдогчийн судалгаа гаргах;

Дээрх зааврын хүрээнд хорих ангийн нийгмийн ажилтнууд хоригдлыг нийгэмшүүлэх үйл хэргээ гүйцэтгэсээр иржээ. Судалгааны ажлын явцад бид нийт 21 хорих ангийн 2015-2020 оны хоорондын нийгэмшүүлэх ажлын тайлан мэдээнд дүн шинжилгээ хийн, тухайн үед мөрдөгдөж байсан зааврын хэрэгжилтийг анги тус бүрээр болон жилээр гарган нэгтгэн үзлээ.

Хүснэгт 4. ШШГЕГ-ын харьяа хорих ангиудын нийгэмшүүлэх үйл ажиллагааны зааврын хэрэгжилтэд өгсөн үнэлгээ /2015-2020/


Хорих анги	ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 сарын 10-ны өдрийн 107 дугаар тушаалаар батлагдсан "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"-ын 60 заалтаар дүгнэхэд			ШШГЕГ-ын даргын 2018 оны 07 сарын 03-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан"Нийгмийн ажлын аргачилсан заавар"-ын 41 заалтаар дүгнэхэд		Нийлбэр
	2015	**2016**	**2017**	**2018**	**2019**	
401	58.3%	56.6%	51.6%	56.0%	78.0%	**61,9%**
405	58.3%	68.3%	65.0%	65.8%	29.0%	**57,2%**
407	73.3.%	73.3%	73.3%	82.9%	75.6%	**75,6%**
409	65.0%	65.0%	60.0%	56.0%	80.4%	**65,2%**
411	65.0%	73.3%	68.3%	56.0%	65.8%	**65,6%**
413	71.6%	70.0%	71.6%	75.6%	80.4%	**73,8%**
415	63.3%	51.6%	51.6%	73.1%	78.0%	**63,5%**
417	53.3%	68.3%	60.0%	65.8%	85.3%	**66,5%**
419	56.6%	58.3%	33.3%	68.2%	78.0%	**58,8%**
421	63.3%	63.3%	66.6%	68.2%	73.1%	**66,9%**
423	56.6%	51.6%	45.0%	65.8%	68.2%	**57.4%**
425	65.0%	58.3%	37.0%	68.2%	78.0%	**61,3%**
427	75.0%	68.3%	65.0%	78.0%	73.1%	**71,8%**
429	65.0%	58.3%	58.3%	60.9%	58.5%	**60,2%**
433	68.3%	56.6%	71.6%	82.9%	70.7%	**70,2%**
435	60.0%	65.0%	58.3%	78.0%	80.4%	**68,3%**
437	73.3%			70.7%	73.1%	**72,7%**
439	56.6%	66.6%	68.3%	78.0%	80.4%	**69,9%**
441	2019 оноос нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж эхэлсэн.					
445	71.6%	61.6%	63.3%	75.6%	82.9%	**71.0%**
457	Архивын нэгж үүсгэж тайлан хадгалагдаагүй.					
461	51.6%	53.3%	50.0%	70.7%	68.2%	**58,7%**

Хүснэгтээс харахад хорих ангиудын нийгэмшүүлэх ажлын зааврын биелэлт 55-75 орчим хувьтай байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл энэ нь нийгмийн ажлын зааварт байна уу, эсвэл үйл ажиллагаа, зохион байгуулалтандаа байна уу гэдгийг анхаарах цаг нэгэнт болжээ.

Түүнчлэн судалгааны ажлын явцад өмнө дурдсанчлан урьд хорих ял эдэлж байгаад дахин гэмт хэрэг үйлдэн хорих ял шийтгэгдсэн ял эдэлж буй


хоригдлуудаас авсан судалгааны дүнг анхаарч үзлээ. Бид судалгааны хүрээгээ 2015-2020 оны хооронд гэж авсан бөгөөд энэ хугацаанд 2015 онд-4506, 2016 онд-4567, 2017 онд- 2942, 2018 онд-3525, 2019 онд-3933 буюу нийт-19473 хоригдол давхардсан тоогоор ял эдэлж байсан байна.

Зураг 9. 2015- 2019 оны нийт хорих ял эдлэгсэдийн судалгаа:




Дээрх ял эдэлж байсан хоригдлуудаас 2015 онд 3445, 2016 онд 1324, 2017 онд 2918, 2018 онд 1813, 2019 онд 2532 буюу нийт-12032 хоригдол суллагдсан байна.

Зураг 10.Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн судалгаа /2015-2020/:



Нийт суллагдсан хоригдлуудаас зөвхөн хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоосон хоригдлуудыг судлан үзвэл 2015 онд 1167 буюу 33,8% , 2016 онд 997 буюу 75,3%, 2017 онд 1115 буюу 38,2%, 2018 онд 1068 буюу 58,9%, 2019 онд 1414 буюу 55,8% нийт-5761 буюу 47,8% нь суллагдсан байна.


Зураг 11.Хугацааны өмнө суллагдсан хоригдлуудын судалгаа /2015-2020/:



Дээрх хугацааны өмнө суллагдсан хоригдлууд нь бүгд засрал хүмүүжлээ олсон, бүрэн нийгэмшсэн гэсэн үндэслэлээр суллагдсан байгаа ба давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудын 70 орчим хувь нь дээрх хугацаанд хамаарч байгаа нь нийгэмшүүлэх ажлын үр нөлөөнд эргэлзээтэй байдлыг төрүүлж байна.


Давтан гэмт хэрэг үйлдсэн хоригдлын тоо 2015 онд 2794 буюу 66,0%, 2016 онд 2172 буюу 47,5%, 2017 онд 1289 буюу 9,8%, 2018 онд 1614 буюу 45,7%, 2019 онд 1910 буюу 48,5% нийт-9779 буюу 50,2% нь байна.

Зураг 12.Давтан гэмт хэрэг үйлдэн хорих ял эдлэгсэдийн судалгаа /2015-2020/:



Судалгаанд оролцогчдоос “таныг давтан гэмт хэрэг үйлдэхэд хорих ангид ял эдэлж байсан байдал нөлөөлсөн үү” гэсэн асуултад 213 буюу 18 хувь нь тийм, 860 буюу 68 хувь нь үгүй, 175 буюу 14 хувь нь бага зэрэг нөлөөлсөн гэж хариулсан.

Зураг 13.Давтан гэмт хэрэг үйлдэгчдээс авсан судалгааны дүн /2015-2020/:



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭН ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ СУДЛАХ НЬ



О.БАЯРЖАРГАЛ
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн ахлах багш, ахмад

Товч агуулга: Үндэсний болон олон улсын судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл нь сэтгэцийн болон бие бялдрын эрүүл мэнд, эдийн засгийн бие даасан аюулгүй байдалд төдийгүй хүүхдүүдийн нийгэмшүүлэх, сэтгэцийн болон бие махбодийн хэвийн өсөлтөд нөлөөлдөг болохыг харуулж байна. Судалгаанаас үзэхэд 3211 хүн гэмтэж бэртсэн, 64 хүн гэр бүлийн хүчирхийллийн улмаас нас баржээ. Үүний 2708 нь хөнгөн, хүнд, хүндэвтэр гэмтэлтэй болох нь тогтоогджээ. (Г.Ганбаатар, 2015) Гэсэн хэдий ч хөнгөн гэмтэл нь хүний амь насанд аюул занал учруулахгүй тул зарим хөнгөн гэмтэл нь хамрын яс хугарах, шүд гэмтэх зэрэг гоо үзэсгэлэнгээ мөнхөд алддаг гэж үзэх хэрэгтэй.

“Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй эмэгтэй ялтнууд / хоригдлууд / өөрсдийгөө үнэлэх чадвар багатай, өөртөө итгэлгүй байдал, ёс суртахууны хохирол, зан авиртай байх хандлагатай байдаг, ихэвчлэн тусалж, тусалж чадах хүмүүстэй харьцдаггүй, зарим тохиолдолд тэд архи, мансууруулах бодисноос хамааралтай байдаг”. (ХЭҮК, 2007)

Нэмж дурдахад тэд удаан хугацаанд уулзаагүй, утсаар ярихгүй байгаа эсвэл хүүхдүүдээ асрамжийн газарт амьдардаг гэх зэргээр гэр бүлийнхэнтэйгээ холбоо тасрах магадлалтай. Шоронгоос гарсны дараа тэд амьдрах, явах газаргүй тул рецидивтэй байж болзошгүй юм.

Тиймээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэй хоригдлуудын ёс суртахууны хохирол, батерейг нөхөн сэргээх шаардлагатай байна. Түүнчлэн тэдэнд тулгарч буй бэрхшээлийг даван туулахад нь дэмжлэг үзүүлж, нийгэмд бие даан ажиллаж, амьдарч, гэр бүлийн харилцаагаа үргэлжлүүлэхэд нь туслах болно.

Энэхүү судалгааны зорилго нь эмэгтэй хоригдлуудын нийгмийн үйлчилгээний чухал асуудлуудыг танилцуулах явдал юм.

Abstract: National and international study shows that family violence affects not only mental and physical health, independent security of economy but also children’s socialization, mental and physical normal growth.

3211 people have injured and 64 people died of family violence. 2708 of them have been identified injuries light, serious and more serious. (Г.Ганбаатар, 2015) However light injury is not threatened life, we should consider that some light injuries are forever loss of beauty as nasal bone fracture and tooth damage.

“Female convicts /inmates/ caused by family violence tend to be lower self-evaluability, self distrust, to have moral damage and battery, often no communication with people who can support and assist, in some cases, they depend on alcohol and drugs”. (ХЭҮК, 2007)

In addition, they may lose touch with their family because of not meeting and talking on the phone for a long time or their children living in a fostering. They could be recidivous after being released from prison because of not having any places to live or go.

Therefore, moral damage and battery of female inmates caused by family violence is required to be rehabilitated. Moreover they shall be supported to overcome their difficulties, managed to work and live in the society independently and assisted to continue their family communication.

The purpose of this study is to present crucial issues on the social service for female inmates.

Түлхүүр үг: Гэр бүл, хүндрэл бэрхшээл, сэтгэл зүйн дарамт, айдас түгшүүр

Key word: Family, problems, stress, anxiety

Хүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл хэлбэр нь аливаа хэлбэрийн хүчирхийлэл бөгөөд түүний дотор ураг төрлийн холбоотой хүмүүсийн хооронд үйлдэгддэг гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг мөн болохыг өнөөдөр дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч түүнтэй тэмцэх аргыг эрэлхийлэх болсон. “Сүүлийн 5 жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 3211 иргэн хохирсны 2870 буюу 89,3 хувь нь эмэгтэйчүүд өртсөн байна”. (Ганбаатар, 2015, х.3)

Гэр бүлийн аль нэг гишүүн нь гэр бүлийн харилцаанд давамгай байдал тогтоох, бусад гишүүдийг эрхшээлдээ байлгах зорилгоор хүчирхийлэл үйлддэг байна.

Мөн Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн таслан шийдвэрлэх тогтоолд хийсэн судалгаанд тухайн онд улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн хэргийн улмаас 36 хүний амь нас хохирч, 44 хүн хүнд, 80 хүн хүндэвтэр, 270 хүн хөнгөн гэмтэл авч 37 сая төгрөгний хохирол учирсан гэж тогтоогджээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрүүл мэнд ямар их хохирдог болохыг дээрх судалгаануудын дүн харуулж байна. Гэвч эмнэлэгт хандсан хохирогчдын тоо нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд эмнэлэгт хандаагүй хохиргочдын тооноос мэдэгдэхүйц бага тоо болохыг ХЭҮТ-ийн Хамгаалах байраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн бүртгэлд хийсэн судалгааны үр дүн баталж байна. Азийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ХЭҮТ-өөс хийсэн судалгаагаар тус төвийн Хамгаалах байраар үйлчлүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид гэр бүлийн хүчирхийлэлд өртөж эхэлсэнээс хойш дунджаар 5-7 жилийн дараа л албан ёсны дэмжлэг туслалцаа авахыг хүсэн хууль цагдаагийн байгууллагад ханддаг болохыг тогтоожээ. Мөн хамгаалах байраар үйлчлүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дөнгөж 5 хүртэлх хувь нь эмнэлэгийн туслалцаа авдаг гэж мэдээлжээ. Энэ бүгдээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөж эрүүл мэндээрээ хохирсон нийт хохиргчдын тоо хэмжээ, эмнэлгийн үйлчилгээ авсан хохирогчдын тооноос хамаагүй их байх хандлага өндөр байна.

Гэр бүлийн хүчирхийлэл биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй сэтгэцийн эрүүл мэндэд бас давхар нөлөөлнө. Хүчирхийлэл үйлдэгчийн байнгын дарамт, хүчирхийлэл заналхийлэл, улмаар гэр бүлийн хүчирхийлэгч хохриогч эмэгтэйчүүдийг буруушаах нийгмийн сөрөг хандлагад автсан хохирогч бурууг өөрөөсөө хайх ба өөрийгөө буруутгах тохиолдол түгээмэл. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд эмнэлэгт хандахадаа ихэвчлэн тодорхой биш өвчний зовиуртай эсвэл сэтгэл санааны гүн хямралтай гэсэн зовиуртай эмнэлэгт ханддаг байна. /Garza, 2002/

Кампбелл ба Левандовский Жеффе нарын тусдаа бие даан хийсэн судалгаагаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдийн дунд сэтгэл санааны гүн хямрал, юмнаас айж байнга санаа зовох, бүх биеэр нь өвдөх, гэмтлийн дараах сэтгэл сананы хямралын шинжүүд илрэх нь хяналтын бүлэгтэй харьцуулахад илүү өндөр байв.

Мөн Роз, Хамптон ба Гэллис, Мичэль ба Ходсон нарын судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг харьцуулахад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдтэй харьцуулахад, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн өөрийн үнэлэмж доогуур, өөртөө итгэх итгэл муу, тэднийг дэмжин туслах хүмүүстэй холбоо багатай, бусдаас илүү их тусгаарлагдсан байсан нь илэрчээ. Өөрийгөө хүчирхийллийн шалтгаан гэж үзэх явдал, өөрийн үнэлэмж муутай байх хувийн шинж, хүчирхийлэл үйлдэгч рүү буцаж очих шийдвэр гаргасан зэрэг нь хоорондоо хүчтэй холбоотой гэж илэрсэн байна.

Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэл нь сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр хэрхэн нөлөөлж буйг нарийвчлан судалсан дээрх судалгаануудтай адил төрлийн судалгааг Монголд хийсэн судалгаа хангалтгүй боловч гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдтэй ажиллаж, тэдний нөхцөл байдлыг мэдэх Монгол судлаач, мэргэжилтнүүдийн дүгнэлт, судалгааны дүнгүүд нь гэр бүлийн хүчирхийллийн хор нөлөөний тухай их мэдээлсэн байдаг. Тэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд нь сэтгэл санааны хямрал гутралд орсон, өөрийн үнэлэмж доогуур, өөртөө итгэх итгэл муу байдаг нь олон жилийн хүчирхийлэлд өртөж хүчирхийллийн гүн гүнзгий айдаст автсан, тэднийг дэмжин туслах хүмүүстэй холбоо багатай, бусдаас илүү их тусгаарлагдсан байсан нь илэрчээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэргүүд нь нэг талаас гэр бүлийн гишүүд хоорондын үл ойлголцол, үл хүндлэл, үл итгэлцэл, хардалт, өс хонзон, таарамжгүй харьцаа, бусдын өдөөн хатгалт, танхай балмад зан зэрэг гэр бүлийн харилцаанаас үүдэлтэйгээр үйлдэгддэг бол нөгөө талаас хүчээр дарлагдсан буюу хүндээр доромжлогдсон санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочирсон үед хүчирхийллээс үүдэлтэйгээр үйлдэгддэг байна.


Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн орчинд, далд хэлбэрээр үйлдэгддэг тул гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтны гэмт хэргийн гэрч, хохирогч нь тэдний гэр бүлийн гишүүн, төрөл садан, ойр дотны хүн байдаг.

Хүснэгт 1. Хорих ялаар шийтгүүлсэн хугацаа

№	Хорих ялаар шийтгүүлсэн хугацаа (жилээр)	Хувь
1.	23	3
2.	15	10
3.	11	14
4.	10	57
5.	4-7	11


Та хэдэн жилийн хорих ялаар шийтгүүлсэн бэ? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 57 хувь нь 10 жил, 14 хувь нь 11 жил, 10 хувь нь 15 жил, 3 хувь нь 23 жил, 11 хувь нь 4-7 жил гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс харахад гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн талаас дээш хувь нь 10-15 жилийн хорих ялаар шийтгүүлсэн байна.

Зураг 1. Боловсролын түвшин



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж ял эдэлж буй хоригдогчдийн талаас илүү хувь нь бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой байгаа нь боловсролын түвшингээс хамааран гэр бүлийн хүчирхийлэлтэй нөхцөл байдлаа таслан зогсох, шийдвэрлэх зөв гарцыг олж чадаагүйтэй холбон тайлбарлаж болох юм.

Зураг 2. Гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл



Та гэмт хэрэг үйлдсэн шалтгаанаа юутай холбон тайлбарлах вэ? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 86 хувь нь архидалтаас үүдэлтэй дарамт, шахалт, 7 хувь нь гомдол цөхрөл, итгэмтгий зан, 7 хувь нь гэр бүлийн таагүй харилцаа, миний өөрийн зан араншин гэж хариулсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааг таслан зогсоохын тулд ямар зүйлүүдийг хийсэн талаар хоригдогчдын хариулсан хариултыг нэгтгэн үзэхэд дараах хариултыг өгсөн байна. Үүнд:

- Цагдаад хандаж байсан, мөн эрүүлжүүлэхэд өгч байсан
- Нөхрөөсөө салж тусдаа амьдарсан боловч гуйгаад ирэхээр нь гайгүй болчих болуу гэж итгэсэн
- Аргадаж учирлаж их хэлж, ойлгуулахыг боддог байсан
- Салъя гэж хэлээд 2 гараа хугалуулж байсан

- Үргэлж уучилдаг байсан
- Үгээр нь байдаг байсан
- Хүүхэд гаргуул архи уухаа болж магадгүй гэж бодоод хүүхэдтэй болсон
- Ямар нэг зүйл хийж байгаагүй
- Хаана хандахаа мэдэхгүй байсан

...цагдаад хандаж, эрүүлжүүлэхэд хонуулж тухайн үеийн нөхцөл байдлыг шийдсэн боловч маргааш нь гаргаж авах гэж өөрөө мөнгө төлдөг, бас чи яасан их хүн бариулдаг юм гээд бүр их зоддог болохоор ахиж цагдаад мэдэгдэхээ больсон.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж ял эдэлж буй эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаас

Эдгээрээс харахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааг таслан зогсоохын тулд зөвхөн цагдаагийн байгууллагад л ханддаг байсан боловч энэ арга хэмжээ нь буцаад өөрт нь илүү дарамт үүсгэдэг нь харагдаж байна. Мөн энэ тохиолдолд үр дүнтэй үйлчилгээ авах эрх зүйн зохицуулалт төдийлөн хангалттай бүрдээгүйг харж болохоор байна.

Хүснэгт 2. Бие махбод болон сэтгэл санаанд илрэх шинж тэмдэг

№	Шинж тэмдэг	Байнга	Заримдаа	Огт үгүй
1.	Нойр хулжих	79%	21%	-
2.	Толгой өвдөх	70%	30%	-
3.	Зүрх савлах	70%	27%	3%
4.	Чичирч салганах	45%	55%	-
5.	Тодорхойгүй шалтгаанаар айж түших	62%	38%	-
6.	Сэтгэл санаагаар унах, хямрах	59%	41%	-
7.	Маш их ганцаардах	48%	52%	-
8.	Ичих	21%	79%	-

Дээрх шинж тэмдгүүд хэр удаан хугацаанд илэрснийг тодруулж асуухад 55 хувь нь хүчирхийлэлд өртөж эхэлснээс хойш одоог хүртэл, 38 хувь нь хорих ангид ирээд 1-2 жилийн дараа, 7 хувь нь хорих ангид ирээд 6 сар хүртэл хугацаанд гэж хариулжээ.

Судалгаанаас харахад нийт судлуулагчдын талаас илүү хувь нь хүчирхийлэлд өртөж эхэлснээс хойш одоог хүртэл дээрх шинж тэмдэг илэрч байна гэж хариулсан нь олон жилийн хүчирхийллийн улмаас гүн гүнзгий айдас, түгшүүр нь өөрөө эдгээр шинж тэмдгийг үүсгэж байдаг. Мөн судалгаанд мэргэжилтнүүд эдгээр бэрхшээлүүд байгаа гэж үздэгч

тасралтгүй үргэлжлэх мэргэжлийн үйлчилгээ үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсний улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийнх нь насны байдал

№	Өгөгдөл	Хувь
1.	0-18 насны хүүхэдтэй	52
2.	19-25 насны хүүхэдтэй	23
3.	25-аас дээш насны хүүхэдтэй	25


Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийн насны байдлыг нь судалж үзвэл нийт судалгаанд оролцогчдын 52 хувь нь 0-18 насны хүүхэдтэй, 23 хувь нь 19-25 насны хүүхэдтэй, 25 хувь нь 25-аас дээш насны хүүхэдтэй гэж хариулсан байна.

Хүснэгт 4. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсний улмаас гэмт хэрэг үйлдэн ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүдийг нь халамжилж буй хүмүүс

№	Өгөгдөл	Хувь
1.	Ах дүү нарын асаргаанд	34
2.	Ээж буюу эмээгийн асаргаанд	31
3.	Тусдаа гарсан	14
4.	Төрсөн эцгийнхээ асаргаанд /*дахин гэрлэлт болон дагавар*/	7
5.	Асрамжийн газар (өнөр бүл, энэрэл)	7
6.	Ах эгч нарынхаа асаргаанд	4
7.	Хохирогчийн талд	3

Ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хүүхдүүд хэний асаргаанд байдгийг судалж үзвэл нийт судалгаанд оролцогчдын 34 хувь нь ах дүү нарын асаргаанд, 31 хувь нь ээж буюу эмээгийн асаргаанд, 14 хувь нь тусдаа гарсан, 7 хувь нь төрсөн эцгийнхээ асаргаанд /*дахин гэрлэлт болон дагавар*/, 7 хувь нь асрамжийн газар (өнөр бүл, энэрэл), 4 хувь нь ах, эгчийн асаргаанд, 3 хувь нь хохирогчийн талд гэж хариулсан байна. Эндээс харахад дээрх нь судлуулагчдын хамгийн их санаа зовж, сэтгэл зүйн бэрхшээл үүсгэдэг асуудлын нэг бөгөөд энэ нь ярилцлагын явцад ч гэсэн илэрч байсан.

Зураг 3. Хүнд хэцүү байдаг асуудал



Өөрт тань хамгийн хүнд хэцүү байдаг 3 асуудлыг нэрлэн үү? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 59 хувь нь гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовдог, 28 хувь нь айж түгшиж, сэтгэл санаа үргэлж хямардаг, нийгэм хэрхэн хүлээж авах бол гэсэн айдастай байдаг, 13 хувь нь өөрийн эрүүл мэнддээ санаа зовдог гэсэн хариулт өгсөн байна.

Харин Гэр бүлийн хүчирхийлийн улмаас гэмт хэрэг үйлдэж ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн зүгээс нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд гардаг хүндрэл бэрхшээлийг судалгаанд оролцсон мэргэжилтнүүд /нийгмийн ажилтан, сэтгэл зүйч/ дараах байдлаар хариулсан байна.


• Гэр бүлийн хүчирхийлэлд байсан хүн ихэíхдээ бүх зүйлээ ярихаас эмээдэг, дотроо хадгалдаг тэр бүр асуудлаа ярьдаггүй, айдастай, тогтворгүй байдаг

• Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд зохих мэдлэг дутмаг байх

• Ял эдэлж байгаа эмэгтэйчүүдийн сэтгэл зүй маш эмзэг байдаг учир орчиндоо дасан зохицох нь удаан байдаг

Дээрх судалгаанаас харахад үйлчлүүлэгчдийн хувьд хамгийн их санаа зовдог зүйл нь гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовдог гэж үзсэн байхад, мэргэжилтнүүдийн өгсөн хариултаас эдгээр зүйлүүдийг чухал гэж үзээгүй байна.

Зураг 4. Хүнд хэцүү асуудлаа даван туулж буй байдал



Эдгээр хүнд хэцүү зүйлсийг та хэрхэн даван туулж байна вэ? гэсэн асуултанд нийт судлуулагчдын 37 хувь нь одоог хүртэл даван туулж чадаагүй, 31 хувь нь өөрийн сэтгэлийн тэнхээгээрээ даван туулж байна, 14 хувь нь хорих ангид ирснээс хойш ажил хийж эхэлснээрээ аажмаар мартагдана (*энд орсноос хойш ажил төрөл хийвэл хэнд ч гологдохгүй ажиллаж чадна гэдгээ ухаарч өөртөө итгэлтэй болсонцаашид ч зорьсондоо хүрэхийн тулд гараад сайн ажиллана*), 14 хувь нь хамгийн их

итгэдэг хүнтэйгээ ярьдаг, 7 хувь нь эмчилгээ хийлгүүлж байна гэсэн хариулт өгсөн байна.

Судалгаанаас харахад судлуулагчдын 68 хувь нь одоог хүртэл даван туулж чадаагүй буюу өөрийн сэтгэлийн тэнхээгээрээ даван туулж байнагэсэн хариултыг харахад (*зураг 3*) - дээр гарсан гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовоодог асуудлууд давхцаж байгаа нь үүний гол шалтгаан болж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдэд үйлчилгээ хүргэхэд хэнтэй хамгийн их хамтран ажиллах шаардлагатай болдог вэ? гэсэн асуултанд мэргэжилтнүүд **/нийгмийн ажилтан, сэтгэл зүйч/** дараах хариултыг өгсөн байна.

- Мэргэжлийн сэтгэл зүйч, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах төв
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой манай оронд мэргэжлийн байгууллага ховор байдаг, түүнийг өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтрах
- Төрийн болон төрийн бус байгууллага
- Бясалгалын төв
- Төлөөлөгч
- Шашны байгууллага

Эдгээрээс харахад хорих ял эдэлж буй эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд гэр бүлтэй нь хамтран ажиллах шаардлага нэн чухал гэдгийг илтгэж байгаа ч мэргэжилтнүүдийн хувьд гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг тасралтгүй хангах байдлаар үйлчилгээг үзүүлдэггүй байдал илэрч байна.


Харилцааны хувьд гардаг бэрхшээлийг судалж үзэхэд 49 хувь нь ямар нэг хүндрэл гардаггүй, 27 хувь нь бусад хоригдогчтой ойлголцоход хэцүү байсан, 17 хувь нь сэтгэлээр их унадаг,7 хувь нь албан хаагчдын ялгаварлан гадуурхалт гэж хариулсан байна.

Харин ямар нэг хүндрэл гардаггүй гэсэн хариултыг судлаж үзэхэд тэд дараах асуудлаас үүдэн бусадтай төдийлөн харилцдаггүй болох илэрсэн.

- *Гэр бүлийн байнгын хэрүүл, зодуур дунд байсан учир аливаа зүйлээс их айж түгших зүйл их байнга байдаг*
- *Бусадтай харилцахдаа хүртэл өөрийн мэдэлгүй айсан байдалтай байдаг*
- *Бусадтай ярилцаж, өөрийн тухай ярьж чаддаггүй*
- *Өөрийгөө ойлгуулах чадвар муу учраас, олон хүнтэй юм ярьдаггүй*
- *Дуу цөөтэй болохоор хэн нэгэнтэй харилцахад хэцүү байдаг*

Эдгээр асуудлын аль нь танд хамгийн чухал гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчид харилцааны чадвар маш чухал гэж 65 хувь, чухал гэж 35 хувь, тунгаан бодох чадвар маш чухал гэж 59 хувь, чухал гэж 41 хувь, шийдвэр гаргах чадвар маш чухал гэж 55 хувь, чухал гэж 45 хувь, хорт зуршлаас татгалзах чадвар маш чухал гэж 55 хувь, чухал гэж 45 хувь, чухал биш гэж 3 хувь, сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар маш чухал гэж 62 хувь, чухал гэж 38 хувь, бусдыг мэдэрч ойлгох чадвар маш чухал гэж 41 хувь, чухал гэж 59 хувь, төлөвлөх чадвар маш чухал гэж 34 хувь, чухал гэж 66 хувь, бусадтай холбоо тогтоох чадвар маш чухал гэж 41 хувь, чухал гэж 59 хувь, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх чадвар маш чухал гэж 48 хувь, чухал гэж 52 хувь, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар маш чухал гэж 65 хувь, чухал гэж 35 хувь гэж хариулсан байна.

Зураг 5. Мэргэжлийн шинэ мэдээллийг авдаг эх сурвалж



Та хорих ангийн нийгмийн ажилтнуудын нэгдсэн сургалтнаас гадна мэргэжлийн шинэ мэдээллийг хаанаас авдаг вэ? нэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 60 хувь нь интернэт цахим мэдээллийн хэрэгслээс, 20 хувь нь шинээр гарсан ном, сэтгүүл, 20 хувь нь нийгмийн ажилтнуудын нэгдсэн сургалтанд одоохондоо хамрагдаагүй байна гэж хариулсан байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа эмэгтэй хоригдлыг нийгэмшүүлэх ажлын тулгамдсан асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийлээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг үйлдэн хорих ял эдэлж байгаа эмэгтэй эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, айж түгшиж, сэтгэл санаа үргэлж хямардаг, нийгэм хэрхэн хүлээж авах бол гэсэн айдас зэрэг нилээдгүй асуудлууд тулгардаг байна.

Эдгээр асуудлыг хэрхэн даван туулж байгааг харахад хорих ангид ирснээс хойш ажил хийж

эхэлснээрээ аажмаар мартагдаж байгаа (*энд орсноос хойш ажил төрөл хийвэл хэнд ч гологдохгүй ажиллаж чадна гэдгээ ухаарч өөртөө итгэлтэй болсонцаашид ч зорьсондоо хүрэхийн тулд гараад сайн*

ажиллана), хамгийн их итгэдэг хүнтэйгээ ярьдаг, эмчилгээ хийлгүүлж байна асуудлаа шийддэг байхад одоог хүртэл даван туулж чадаагүй хүмүүсийн асуудал нь (*зураг 2*)-дээр гарсан гэр бүл, үр хүүхдүүдээ маш их санаж, тэдэндээ санаа зовсон сэтгэл зүй нь тэдэнд бэрхшээлийг үүсгэдэг байна. Энэ хэрэгээр ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хувьд хүүхдүүд нь тэдний хамаатан садан болон асрамжийн газар, хохирогчийн талд байгаа энэ нөхцлийг бий болгоход хүргэж байна.

Мөн мэргэжилтнүүдийн зүгээс эдгээр хүмүүст үйлчилгээ үзүүлэхдээ гэр бүл болон бусад ойр дотны хүмүүстэй төдийлөн хамтарч ажилладаггүй болох нь судалгаанаас харагдсан.

Иймээс тухайн зорилтот бүлгийн үйлчлүүлэгчдэд хорих ангийн нийгмийн ажилтан гэр бүлтэй нь хамтран ажиллах шаардлага нэн чухал гэдгийг илтгэж байна.

Нийт судлуулагчдын талаас илүү хувь нь хүчирхийлэлд өртөж эхэлснээс хойш одоог хүртэл бие махбодь болон сэтгэл санаанд[1] нь сөрөг шинж тэмдэг илэрч байгааг судалгаанаас харахад олон жилийн хүчирхийллийн улмаас гүн гүнзгий айдас, түгшүүр тогтсон нь өөрөө эдгээр шинж тэмдгийг үүсгэж байдаг. Иймээс нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн тасралтгүй үргэлжлэх мэргэжлийн үйлчилгээ үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна.

Харин нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн хувьд үйлчлүүлэгчийн тодорхойлсон дэмжлэгтэй адил хэрэгцээг тэдэнд шаардлагатай гэж мэргэжилтний хувьд тодорхойлж байгаа ч үйлчилгээг хүргэхдээ төдийлөн анхаардаггүй байдал ажиглагдаж байна. Мөн мэргэжилтнүүдээс авсан судалгааны үр дүнгээс харахад тэд дийлэнхдээ интернэт, цахим хэрэгслээс мэдээллийг авдаг нь тэдэнд мэргэжлийн арга зүйн туслалцаа, дэмжлэг тогтмол тасралтгүй байдлаар хүргэх нь чухал байна.

Судалгаанаас харахад ял эдэлж буй эмэгтэйчүүдийн хувьд дараах чадварууд тэдэнд хамгийн чухал */Харилцааны чадвар, Тунгаан бодох чадвар, Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах чадвар, Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх чадвар, Бусадтай холбоо тогтоох чадвар, Өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх чадвар, Хорт зуршлаас татгалзах чадвар, Шийдвэр гаргах чадвар*/ гэж үзсэн байхад мэргэжилтнүүд ч гэсэн эдгээрийг чухал гэж үздэгч энэ чиглэлээр тодорхой, үр дүнтэй сургалт, хөтөлбөр хэрэгжүүлдэггүй болох нь харагдсан.

Эдгээрээс харахад нийт ял эдэлж буй эмэгтэйчүүд болон зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх болон зан үйлд нөлөөлөх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, тэдний ар гэрийнхэн болон зарим

[1]Хүснэгт 2

тохиодолд хохирогчийн талтай хамтран ажиллах, эдгээр үйлчилгээг хүргэх мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр тасралтгүй хангаж, мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Ном зүй

1. Батхуяг, С., Төртогтох, Б., Цогзолмаа. Н. (2015). Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник. Улаанбаатар хот. Хүслийн өнгө хэвлэх үйлдвэр.

2. Даваа-Очир, Д. (2001). *Хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд холбогдолтой эрх зүйн баримт бичгийн эмхтгэл*. Улаанбаатар хот. Тоонотпринт хэвлэлийн компани.

3. Жадамбаа, Б., Чимэдлхам, Ц., (2011).*Судалгааны арга зүй*. Улаанбаатар хот. Гэрэлт судар хэвлэлийн компани.

4. Лхагва, А. (2008). *Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал.*Улаанбаатар хот. Тоонотпринт хэвлэлийн компани.

5. Лузгин,С.,А., Кузнецов, М.,И., Казанцев, Б., Н., (2009). *Хорих байгууллагын нийгмийн ажил*. Улаанбаатар хот. Хууль зүйн үндэсний хүрээлэн хэвлэх үйлдвэр.

6. Мягмар, О. (2000). *Хувийн дасан зохицохуй.*Улаанбаатар хот.

7. Өлзийтунгалаг, Х., Батхишиг, А., (2008). *Гэр бүлийн хүчирхийлэлийг судлаж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь*. Улаанбаатар хот.

8. Ичинхорлоо, Ш. (2007). *Судалгааны ажлын үндэс.* Улаанбаатар хот.

9. Curt T. Griffiths, Ph.D, Yvon Dandurand, Danielle Murdoch. The social reintegration of offenders and crime prevention. Research report: 2007

10. Gwen Robinson, Lain D Grow. Offender rehabilitation. Theory and Practice.

11. Brewster.M (2002). Domestic violence theories, research and practical implication

12. Davies.J., Lyon, E (1998). Safety planning with battered women: Complex lives and difficult choices.

13. Garza.M.A. (2002). Evaluation of battered women is shelter: Outcomes to measure effectiveness.

14. Hunter Geboy, C. (1995). Life planning education: A youth development program. Washington, DC: Advocates for Youth

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН ЭРХИЙН БАЙДЛЫН ЕРӨНХИЙ АСУУДАЛ: ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЖИЖҮҮРИЙН БҮРЭЛДЭХҮҮН НОЙРГҮЙ АЖИЛЛАСНААС ЭРҮҮЛ МЭНДЭД НЬ УЧИРЧ БУЙ ХОР УРШГИЙН ТАЛААР



МУРАТЫН ДОСЫМБЕК
ОХУ-ын Дотоод хэргийн яамны
Удирдлагын академийн докторант, ахмад

Хураангуй: Энэхүү илтгэлээр хорих байгууллагын харуул хамгаалалтын жижүүрийн ажилтан үүрэг гүйцэтгэх хугацаанд унтаж амрахгүй ажилласнаас эрүүл мэндэд нь учирч буй хор уршгийг хөндөж, Монгол улс болон ОХУ-ын ижил төрлийн чиг үүрэг бүхий байгууллага жижүүрийн үүрэг гүйцэтгэх алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг судлан, шийдвэрлэх арга замын талаар санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Abstract: This report examines the health effects of Mongolian and Russian organizations on duty, highlighting the health effects of sleep deprivation on duty by prison guards. and to suggest solutions.

Түлхүүр үг: Алба хаагчийн эрүүл мэнд, хорих байгууллага, нийгмийн баталгаа, жижүүрийн үүрэг гүйцэтгэл, хүний нойргүйдэл.

Keywords: Employee health, prison, social security, duty duty, insomnia.

Хорих байгууллага нь шүүхээс гарсан хүчин төгөлдөр шүүхийн тогтоолыг биелүүлэх, төрийг төлөөлж хууль хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, хамгаалах тусгай чиг үүрэг бүхий байгууллага ба нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэнэ[1].

Шүүхээс гарсан хүчин төгөлдөр тогтоолыг биелүүлэгч буюу хорих байгууллагын ажилтны эрүүл мэндийн баталгааг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 286 дугаар зүйлд *“Зөвхөн албан үүргээ*

[1] . Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195 дугаар зүйл. /Шинэчилсэн найруулга/ 2017.06.09. Төрийн мэдээлэл. 2017. № 24 (981), 1586 дахь тал.

гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирсан тохиолдолд олгох тэтгэмж, нөхөх олговор, тусламж болон онцгой нөхцөлийн нэмэгдэл” зэргийг олгохоор хуульчилсан боловч хорих байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар зохицуулалт тусгагдаагүй байна[2].

Энэ талаар бусад тусгай чиг үүрэг бүхий байгууллагын хуулинд тусгагдсан зохицуулалтыг судалж үзэхэд тухайлбал: “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 86 дугаар зүйлийн 86.8 - д *“Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан нь* алба хаагчийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлд чухал зохицуулалт болсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд Ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/220 дугаар тушаалаар ***«ШШГБ-ын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр»***-ийг батлан алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаагаас дурьдвал *“401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг 2017 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон хотын хүрээний анги, салбаруудад алба хааж байгаа 500 гаруй алба хаагчдыг томуугийн эсрэг идэвхжүүлэх вакцинд үнэ төлбөргүйгээр хамруулсан[3]”, “2020 онд алба хаагчдад бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх яриа, үзэг хийж, шинжилгээнд оруулсан”* байна.

Гэвч харуул хамгаалалтын ажилтан жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд унтаж амрахгүйгээр ажиллаж байгаа нь нойр дутагдсанаас үүсэх шинж тэмдэг, дараах хор уршгийг бий болгож байна. Үүнд:

- нойр эртдэх, нойр хойшлогдох эмгэг үүсэж нойрон дундаа аймшигтай, айдас түгшүүртэй зүүд зүүдлэх;
- чих шуугих, нүд бүрэлзэх, ачаалал даахаа болих, анхаарал төвлөрөхгүй байх, уурлаж бухимдан сэтгэлийн хөдөлгөөн сөрөг болох;
- ой тогтоолт муудаж, тархины тогтоох болон суралцахад нөлөөлөх мэдрэлийн эсүүдийн холбоо тасарч хүн мартамхай болох;
- мэдрэлийн эс аажмаар үхэж хүний дархлаа сулрах, хий юм харах;
- дотор эрхтний дамжуулагч эсүүд хорогдож, гадна биеийн эсэргүүцэх чадвартай эсүүд цөөрч хурдан өвчин тусах аюулыг бий болгох;
- зүрх судасны өвчнийг даамжруулахад хүргэх;

---

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 286 дугаар зүйл. /Шинэчилсэн найруулга/ 2017.06.09. Төрийн мэдээлэл. 2017. № 24 (981), 1785 дахь тал.

[3] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан ёсны цахим хуудас. Цахим эх сурвалж URL:http://cd.gov.mn/c/304.

- арьсны гадаргуутай ойрхон байдаг хялгасан судаснуудын цусны эргэлт муудаж нүдийг нь тойрон хөхөлбий туяа татах, нүд улайх, бүлцийх, царай зүс алдах;

- тархины систем доголдох зэрэг албан хаагчийн эрүүл мэнд, бие махбодод муугаар нөлөөлөх хор уршгийг бий болгож байна[4].

Энэхүү асуудлыг бусад ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллага хэрхэн зохион байгуулан ажиллаж байгааг судлахад:

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын дотоод албаны дүрмийн 19 дүгээр зүйлд *“Жижүүр, томилгоот ээлжийн бүрэлдэхүүн ажлын байранд цагийн хуваарийн бус үед унтахыг хориглоно”* гэж заасан нь томилгоот ээлжийн бүрэлдэхүүн хуваарийн дагуу унтаж амрах боломжтойг илэрхийлж байна;

- Цагдаагийн албаны хувьд хөдөө орон нутгийн зам болон хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэх үед алба хаагчид унтаж амрах боломжоор хангах зорилгоор зөөврийн амралтын өрөөтэй автомашиныг тоноглон, үйл ажиллагаанд тогтмол ашиглаж, жижүүрийн бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэх хугацаанд ээлжлэн унтаж амрах боломжоор хангаж байна[5];

- ОХУ-ын ял эдлүүлэх байгууллага нь жижүүрийн бүрэлдэхүүн амрах өрөөг батлагдсан зааврын дагуу тохижуулж, шаардлагатай эд зүйлс, хэрэгслийг хорих ангийн захиргаанаас ханган, алба хаагчид нойргүй ажилласнаас үүсэх өвчин, хор уршгаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна[6];

- ОХУ-ын дотоод хэргийн байгууллага (цагдаагийн алба) нь жижүүрийн тасагт амралтын өрөөтэй бөгөөд алба хаагчид жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд батлагдсан хуваарийн дагуу ажлын ачаалал багассан үед 3 цагаар амрах эрхтэй[7] зэргээр зохион байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд нойргүй ажилласнаас хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай гэдгийн маш олон судлаачид баталсан тул алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажилд анхаарах шаардлагатай.

---

[4] Т.Амартогтох. Төрийн тусгай албан хаагчдын нойрны төвийн эмчийн ярилцлаа. https://www.caaknews.mn/view/8301530/.

[5] Цагдаагийн албаны мэдээллийн цахим сүлжээ. URL:http://chuhal.mn/r/37460 .

[6] Приказ Минюста России, от 5 февраля 2007 года N 48 «Об утверждении Инструкции по организации работы дежурных служб территориальных органов Федеральной службы исполнения наказаний» [Холбооны ял эдлүүлэх байгууллагын жижүүрийн үүрэг гүйцэтгэх албаны ажлыг зохион байгуулах заавар батлах тухай тушаал]/ URL:http://docs.cntd.ru/document/902068556/.

[7] ОХУ-ын Томск хотын цахим хуудас. URL: https://news.vtomske.ru/details/74260-policeiskaya-noch-foto/.

Дүгнэлт

Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах нь түүний албан үүргээ амжилттай, сонор сэрэмжтэй гүйцэтгэх, тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг.

Хорих байгууллагын харуул хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэх хугацаанд унаж амрахгүй ажиллаж байгаа нь хорих ангид тулгамдаж буй харуул хамгаалалтын ажилтны хүрэлцээгүй байдал, одоо ажиллаж байгаа алба хаагчийн эрүүл мэнд нь муудах, хүндээр өвчлөх зэрэг асуудалд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг мөн гэж дүгнэж байна.

Санал

Иймд харуул хамгаалалтын жижүүрийн бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэх хугацаанд тодорхой хэмжээгээр, хуваарийн дагуу унтаж амрах зохицуулалтыг эрх зүйн хүрээнд хийх шаардлагатай байна гэж үзээд дараах 2 саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. ХЗДХСайдын 2017 оны 07 сарын 25-ний өдрийн А/197 тушаалаар батлагдсан “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-д жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд хуваарийн дагуу унтаж амрах талаар нэмэлт өөрчлөлт оруулах;

2, Алба хаагчдын эрүүл мэндийг мэргэжлээс шалтгаалах, нойргүй ажилласнаас үүсэх өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих байгууллагын онцлогт тохируулан харуул хамгаалалтын жижүүрийн алба хаагчийн “Амрах өрөө”-г бий болгох саналуудыг дэвшүүлж байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ОНОГДУУЛАХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ



Б.БОЛОР-ЭРДЭНЭ
Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, ахмад

Товч агуулга: Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хангах мөн албадлагын арга хэмжээг оногдуулах ажиллагааг хэрэгжүүлэх

Түлхүүр үг: Хуулийн этгээд, төрийн бус байгууллага, удирдах зөвлөл, өөрчлөн байгуулах, нэгтгэх, тусгаарлах, хуваагдах

Summary: Implement measures to ensure the legal status of legal entities and impose coercive measures

Key word: Legal entities, non-governmental organizations, boards of directors, reorganization, consolidation, separation and division

Хуулийн этгээд гэдэг бол хөрөнгө төвлөрүүлэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх явцад бий болсон ойлголт юм. Хуулийн этгээд гэдэг нь Монгол Улсын Иргэний Хуульд зааснаар өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ гэсэн байдаг.[1]

Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.

Хуульд өөрөөр заагаагүй бол хэд хэдэн хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болох бөгөөд нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална.

Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

Аливаа байгууллага, нэгдэл хуулийн этгээд байхын тулд тодорхой шинжүүдийг агуулсан байх ёстой.

Хуулийн этгээдийн үйл ажиллагааг иргэний тухай хуулиар зохицуулна. Тухайлбал:

1. Өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй.
2. Өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг хүлээх чадвартай.
3. Үйл ажиллагаанаасаа үүсэх үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг.

[1] Википедиа нэвтэрхий толь

4. Иргэний эрх зүйн харилцаанд иргэдээс гадна аливаа байгууллага өөрийн нэрээр оролцон эрх эдэлж, үүрэг хүлээж байдаг. Эдгээр байгууллага нь хуулинд заасны дагуу байгуулагдаж, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хуулиар тогтоосон журмын дагуу татан буугдах тул “хуулийн этгээд” гэж нэрлэдэг. Мөн Нөхөрлөл компаны хууль, Хоршооны хууль, Аж ахуй нэгжийн хууль, Банкны тухай, Үнэт цаасны тухай гэх мэт бусад хуулиудаар зохицуулдаг. Хуулийн этгээдийг иргэд, бусад хуулийн этгээд, төрөөс дангаараа буюу хамтран байгуулж болно. Ямар төрөл, хэлбэрийн хуулийн этгээд байгуулж байгаагаас шалтгаалан байгуулах журам нь ялгаатай байдаг.

Хуулийн этгээд үүсгэн байгуулах

Төрийн бус байгууллагын дүрэмд дор дурдсан зүйлийг тусгана:

1. Төрийн бус байгууллагын нэр, хаяг
2. Төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсан огноо
3. Төрийн бус байгууллагын зорилго
4. Төрийн бус байгууллагын бүтэц, хяналтын тогтолцоо
5. Удирдах зөвлөлийн эрх хэмжээ
6. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний доод, дээд хязгаар
7. Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх журам, бүрэн эрхийн хугацаа
8. Удирдах зөвлөлийн жилд хуралдах хурлын тооны доод хязгаар
9. Удирдах зөвлөлийн хуралдааныг хүчинтэйд тооцох ирц
10. Удирдах зөвлөлийн хуралдаанаас шийдвэр гаргах журам
11. Төрийн бус байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл журам, энэ тохиолдолд хөрөнгийг хэрхэх тухай
12. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл, журам зэрэг байна.[2]

Компаний тухай хуульд өргөдөл гаргагч хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичиг бүрдүүлнэ.

1. Баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл
2. Хуулийн этгээд байгуулах тухай эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, эсвэл уг шийдвэрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
3. Хуулийн этгээдийн дүрэм
4. Хуульд заасан бол үүсгэн байгуулах гэрээ
5. Гадаадын хуулийн этгээд үүсгэх байгуулагчаар оролцож байгаа бол уг хуулийн этгээдийн тухайн улс дахь улсын бүртгэлийн бичилтийн хуулбар

[2] Д. Булган Захиргааны шийтгэлийн онол практикийн үндсэн асуудал 2011 он 48 дахь тал

6. Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллагаас шалгуулж баталгаажуулсан баримт

7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт зэрэг байна. [3]

Бүртгэх байгууллага нь баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэнэ. Хуулийн этгээд нь бусад байгууллагатай давхцаагүй улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Зарим аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Зөвшөөрлийг ямар байгууллага олгох нь аж ахуйн үйл ажиллагааныхаа төрлөөс хамаарна. Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулдаг.

Хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь өөрчлөн байгуулагдсан буюу татан буугдсанаар дуусгавар болно. Хуулийн этгээдийг нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулахыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Өөрчлөх замаар хуулийн этгээдийн үйл ажиллагааг дуусгахад түүний эрх, үүрэг, хариуцлага өөр хуулийн этгээдэд шилждэг. Өөрчлөх шийдвэрийг эд хөрөнгийнх нь өмчлөгч, эсвэл үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллага гаргана.

Хуулийн этгээд өөчлөгдөн байгуулагдах 5 хэлбэр байна.Үүнд:

1. Хуваагдах
2. Тусгаарлах
3. Өөрчлөгдөх
4. Шинээр байгуулагдах
5. Нэгдэх

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс, эсхүл гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад хөрөнгөнөөс төлбөрийг суутгана. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө хаана, ямар зориулалтаар ашиглагдаж байгаа нь үл хамаарна.[4]

Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч-хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна.

Төлбөр төлөгч нь банк бол тухайн арилжааны банкны Монгол банкан дахь харилцах данснаас хасалт хийх, төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэн төлбөрийг гаргуулна.

---

[3] Компаны тухай хууль 2012 он

[4] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн хөрөнгөөс суутгал хийхдээ уг хуулийн этгээдэд хөрөнгөө итгэмжлэн хадгалуулсан, өөрийн нэрийн өмнөөс аливаа гүйлгээ, төлбөр, тооцоо гүйцэтгүүлэхээр данс эзэмшиж байгаа бусад этгээдийн хөрөнгөөс суутгал хийхгүй.

Энэ зүйлд заасан журмыг хувиараа аж ахуй эрхэлдэг төлбөр төлөгч-иргэнд холбогдуулан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах тохиолдолд нэгэн адил баримтална.

Төлбөр төлөгч-хуулийн этгээд энэ хуульд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар зээлдэгч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч, үүсгэн байгуулагчид мэдэгдэх үүрэгтэй бөгөөд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улмаас бий болсон хөрөнгийн өөрчлөлтийн талаар улсын бүртгэл, татварын байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

Шийдвэр гүйцэтгэгч иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр төлөгч-хуулийн этгээдийн төлбөр гүйцэтгэх чадварт ноцтой нөлөөлөх тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгө байхгүй тохиолдолд уг хуулийн этгээдийн хөрөнгө хэний эзэмшилд байгаагаас үл хамааран дараахь хөрөнгийг хураан авах, худалдан борлуулах, төлбөрт суутгах ажиллагаа явуулна:

1. Мөнгөн хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, бэлэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнд шууд хэрэглэгдэхгүй бусад материал, үнэт зүйл;

2. Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй хөрөнгийн эрх;

Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамааралгүй үл хөдлөх хөрөнгө;

3. Бараа, ажил, үйлчилгээ үйлдвэрлэх, гүйцэтгэхэд шууд хамаарал бүхий хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бараа, материал, бусад түүхий эд, техник, тоног төхөөрөмж, үнэт цаас.[5]

[5] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн бусдын эзэмшилд байгаа мөнгөн болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулах

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банкан дахь харилцах данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгөн хөрөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх

Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийг энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу битүүмжилж, энэ тухай мэдэгдлийг улсын бүртгэлийн байгууллагад даруй хүргүүлнэ.

Мэдэгдэлд уг үл хөдлөх эд хөрөнгийн үнэ, тоо, хэмжээ, байршил, төлбөр авагчийн шаардсан мөнгөн дүнгийн тухай мэдээллийг тусгана.

Мэдэгдлийн хуулбарыг татварын байгууллагад хүргүүлнэ.

Улсын бүртгэлийн байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96.1-д заасан мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд тухайн битүүмжлэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг тодорхойлсон лавлагааг ажлын 3 өдрийн дотор мэдэгдэл өгсөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ирүүлнэ.[6]

Төлбөр төлөгч-хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдах үед төлбөр гаргуулах. Төлбөр төлөгч-хуулийн этгээд нийлэх, нэгдэх, тусгаарлах, хуваагдах, өөрчлөгдөх замаар өөрчлөн зохион байгуулагдсан тохиолдолд Иргэний хуульд заасны дагуу тухайн байгууллагын мөнгөн хөрөнгө болон бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болох үед төлбөр гаргуулах. Төлбөр төлөгч-хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан зэргээр үйл ажиллагааг нь зогсоосон тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийн шаардлагаас илүү гарсан хэмжээгээр хөрөнгийг битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан шийдвэрийг хүчингүй болгож, энэ талаар дампуурлын хэрэг гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч битүүмжилсэн, барьцаалсан, хураан авсан хөрөнгийн үнэ нь гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагын хэмжээнээс илүүгүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах зорилгоор албадан борлуулах, эсхүл төлбөрт суутган шилжүүлэх тухай

[6] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

шийдвэр гаргана. Шаардлагыг нь хангасан гүйцэтгэх баримт бичгийг дампуурлын хэрэг гүйцэтгэгч, эсхүл татан буулгах комисст хүргүүлнэ.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэснээс хойш “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 44.2-т заасан аливаа арга хэмжээг гүйцэтгэхгүй. Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдуулан татан буулгах ажиллагаа эхлүүлсэн, эсхүл дампуурлын хэрэг үүсгэснээс хойш гүйцэтгэх баримт бичиг олгосон, эсхүл ирүүлсэн баримт бичгийн дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулаагүй тохиолдолд гүйцэтгэх баримт бичгийг татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчид шилжүүлнэ. Татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц Иргэний хууль, Дампуурлын тухай хуульд заасан журмын дагуу төлбөр авагчид, эсхүл гүйцэтгэх баримт бичиг ирүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлнэ.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэн дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлснээр үйл ажиллагаа нь сэргэж төлбөрийн чадвартай болсон боловч төлөвлөгөөний хугацаа дуусахад төлбөрийг барагдуулж дуусаагүй тохиолдолд дампуурлын хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлнэ.

Төлбөр авагчийн хүсэлтээр шийдвэр гүйцэтгэгч өөрийн шилжүүлсэн гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангах талаар татан буулгах комисс, дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хуульд нийцсэн эсэхийг шалгаж болно.[7]

Зөрчлийн тухай хуульд хуулийн этгээдэд оногдуулах албадлагын арга хэмжээ.

Шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээд

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна. Зөрчил үйлдсэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, түүнийг санаатайгаар дампууруулсан, татан буулгасан бол доор дурдсан журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

1. Хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
2. Хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;
3. Хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйлдсэн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;

---

[7] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он

4. Хуулийн этгээдийн зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;

5. Компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол толгой компанид;

6. Зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг санаатайгаар татан буулгасан бол торгох шийтгэл, хохирол, хор уршиг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчид;

7. Аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг үндэслэлгүйгээр тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээдэд, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлэн авсан бусад хуулийн этгээдэд шилжүүлэн авсан хөрөнгийн хувь хэмжээгээр.

Хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 5 дахь хэсэгт зааснаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь шийтгэлийн зорилгыг хангах боломжгүй бол шүүгч зөрчил үйлдэгдэх үед тухайн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.[8]

Хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн зөрчлийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн төрөл

Зөрчил үйлдсэн хуулийн этгээдэд торгох шийтгэл оногдуулна. Торгох шийтгэлийг үндсэн, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна.

Торгох шийтгэл гэдэг нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ. Торгох шийтгэлийн хэмжээ нь хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

Зөрчлийн тухай хуулийн 2 дахь хэсэгт заасан нэг торгуулийн нэгж /цаашид “нэгж” гэх/ нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.[9]

---

[8] Зөрчлийн тухай хууль 2017 он

[9] Зөрчлийн тухай хууль 2017 он

Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасны дагуу торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ



Д.НАМУУН
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах дэслэгч

Товч агуулга: Шүүхийн шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж буй алба хаагчдаас иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж буй шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлыг бусад төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчид болон ижил чиг үүрэг бүхий гадаад улсын шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдалтай харьцуулан судласан болно.

Abstract: The legal status of civil, administrative, and enforcement officers involved in enforcing court decisions was compared with that of other special government agencies and foreign bailiffs with similar responsibilities.

Түлхүүр үг: Ачаалал, эрх зүйн байдал, эрх зүйн баталгаа
Keywords: Load, legal status, legal guarantees

Иргэний, захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах, эрүүгийн хэргийн хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийг шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг шийдвэр гүйцэтгэгчид хэрэгжүүлж байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, түүнд тавигдах шаардлага, цалин хөлс, нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгаа хангагдсанаар хуулиар хүлээсэн үүргээ саадгүй биелүүлэх боломжийг бий болгодог.

Шийдвэр гүйцэтгэгчдийг гүйцэтгэж буй чиг үүргийг онцлогоос хамаарч иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэгч, эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нь ялгаатай эрх зүйн зохицуулалтын хүрээнд чиг үүргийг хэрэгжүүлж байна. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй шийдвэр гүйцэтгэгчид нь нийт алба хаагчдын 9.1 хувийг эзэлж байна.

2017 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль шинэчлэн батлагдсанаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тэр дундаа шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд өөрчлөлт орж ажлаас чөлөөлөгдөх хүсэлт,

чөлөөлөгдсөн алба хаагчдын тоо өмнөх онуудтай харьцуулбал өссөн үзүүлэлттэй байна.

Иймд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал нь тэдгээрийн албан үүргээ биелүүлэх баталгааны агуулгыг тодорхойлох шинжтэй учраас уг ойлголтын хүрээнд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын судлан үзэх шаардлагатай байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, баталгааг бусад төрийн байгууллагын эрх зүйн баталгаатай харьцуулан авч үзэхэд төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллагын албан хаагчдын ажлын онцлог болон ажлын ачаалал зэргээс шалтгаалан өөр өөр байдлаар тусгагдсан байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдалд тулгамдаж буй асуудал: Улсын хэмжээнд нийт эрүүгийн, иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан 286 шийдвэр гүйцэтгэгч, 55 ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллаж байна. Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, баталгааг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар баталгаажсан хэдий ч хэрэгждэггүй, хууль сахиулах чиг үүрэг бүхий төрийн бусад албан хаагчдын эрх зүйн баталгаатай харьцуулахад төдийлөн хангалттай бус байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн тогтвор суурьшил, хөдөлгөөний ерөнхий төлөвийг харуулахад өөрийн хүсэлтээр 2015 онд 7 шийдвэр гүйцэтгэгч, 2016 онд 4 шийдвэр гүйцэтгэгч, 2017 онд 6 шийдвэр гүйцэтгэгч, 2018 онд 27 шийдвэр гүйцэтгэгч, 2019 онд 10 шийдвэр гүйцэтгэгч чөлөөлөгдсөн.

Нийт ажиллаж байгаа 286 шийдвэр гүйцэтгэгчийн 103 буюу 36 хувь нь эрэгтэй, 183 буюу 63.9 хувь нь эмэгтэй албан хаагч ажиллаж байна.

Эрх зүйн баталгаа нь төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах эрх мэдлээр илрэн гарч тухайн албан тушаалын үүрэг, эрх, хуулиар тогтоосон хязгаарлалт, хориглолт, албан хаагчийн ажиллах баталгаа, урамшуулал ба хариуцлага гэсэн өөр хоорондоо харилцан холбоотой цогцолбор ойлголт болохын хувьд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал, баталгааны өнөөгийн түвшинг тогтоохын тулд холбогдох албан хаагчдын байр суурийг тодруулах, төгөлдөржүүлэхэд чиглэгдсэн судалгааны дүгнэлт, саналыг боловсруулах зорилгоор нийт шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс судалгаа авсан.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал бүрэн хангагдсан эсэх талаар тодруулахад эрх зүйн байдал хангалттай гэж үзсэн 4 буюу 2.2 хувь, хангалтгүй гэж үзсэн 152 буюу 82.1 хувь, маш муу гэж үзсэн 22 буюу 12 хувь, мэдэхгүй гэж үзсэн 7 буюу 3.7 хувь байгааг дүгнэн үзэхэд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал муу хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Дээрх асуултыг баталгаажуулах үүднээс дараах асуултаар тодруулга хийхэд шийдвэр гүйцэтгэгчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин, эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон гэдгийг судалгааны үр дүн харуулж байна.

ШШГТХ-д заасан боловч дараах эрх зүйн баталгааны хэрэгжилт хангалтгүй байна гэж үзсэн. Тухайлбал хуулийн:

285.5 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаа хаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл, биеийн хүч, галт зэвсэг хэрэглэх эрхтэй.

287.2 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаа хаагч өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжид түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.

287.6 Аймаг, хот хооронд түүнчлэн аймаг, хот дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжин ажиллахаар томилогдсон албаа хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүнд уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын тээврийн үнэлгээгээр тооцож олгоно.

287.8.3 хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг хангах, бусдаас хараат бус байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд цалин хөлсийг нэмэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаанд нь туслах үүрэг бүхий ажилтантай болгох, тусгай хэрэгслээр хангах, шийдвэр гүйцэтгэгчийн эдлэх эрх хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн хувилбар давамгайлж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад урамшууллын тогтолцоо шаардлагатай эсэхийг тодруулахад 167 буюу 90.3 хувь нь шаардлагатай гэж үзсэн байна. Эрх зүйн зохицуулалтанд шинээр хуульчлах гэсэн саналыг 129 буюу 69.7 хувь нь гаргасан байна.

Судалгаанд хамрагдсан шийдвэр гүйцэтгэгч нараас шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг төгөлдөржүүлэхтэй холбоотой саналыг нээлттэй байдлаар авахад нээлттэй асуултанд нийт 136 гүйцэтгэгч өөрийн санал бодлоо илэрхийлсэн байлаа.

Шийдвэр гүйцэтгэгч нараас гаргасан саналыг нэгтгэн авч үзлээ.

1.Илүү цагаар болон амралтын өдөр ажилласны нэмэгдэл хөлс олгох;

2.Энгийнээр шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан жилийг тооцож цэргийн цол олгох;

3.Хөдөө орон нутагт томилогдсон алба хаагчдын орон байрны асуудлыг шийдэж өгөх;

4.Ажлын ачааллыг бууруулах, туслах ажилтантай болох;

5.Тусгай хэрэгслээр бүрэн хангах;

Судалгаанд хамрагдсан шийдвэр гүйцэтгэгч нар өөрсдийн эрх зүйн баталгаа, аюулгүй байдлыг хангах арга зам, гарцыг ийнхүү санал болгосон.

ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрийн биелэлтийг ханган ажиллаж буй алба хаагчдаас иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлж буй шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлыг бусад төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчид болон ижил чиг үүрэг бүхий гадаад улсын шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдалтай харьцуулж үзлээ.

Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангаж буй шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлыг судлан үзэхэд 1996 он хүртэл эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдал бүрэн хангагдаагүй байсан ч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт өндөр, мөнгөн төлбөрийн үүрэг бүхий гүйцэтгэх баримт бичгийн үнийн дүн бага, төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулах, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг нь шийдвэр гүйцэтгэгчдийн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллахад хүндрэл бэрхшээл бага үе байсан гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсад хийгдсэн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гадаад улс орны жишиг хандлагад нийцүүлэх чиглэлээр томоохон эрх зүйн зохицуулалтууд бий болж, улмаар 2002 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг батлан гүйцэтгэсэн ажиллагааны үр дүнгээс хамаарч, шийдвэр гүйцэтгэгчид төрөөс цалин хөлс олгохоос гадна урамшууллын тогтолцоог бий болгож, төлбөр авагчаас төвлөрүүлсэн урамшууллын мөнгөн хөрөнгийн тодорхой хэсгийг шийдвэр гүйцэтгэгчид олгож, тодорхой хэсгээр тэдний үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх тогтолцоог бий болгож, энэхүү эрх зүйн зохицуулалт нь 15 жилийн хугацаанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх харилцааг зохицуулсан.

Шийдвэр гүйцэтгэгч нь төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ гүйцэтгэсэн ажиллагааны дүнгээс мөнгөн урамшуулал авч эхэлснээс шийдвэр гүйцэтгэгчид ажлын байранд тогтвортой ажиллах, тэдний нийгмийн баталгаа нэмэгдэх эрх зүйн зохицуулалт бий болсон ч нөгөө талаас сөрөг үр дагаврыг үүсгэсэн байна.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн тодорхой үнийн дүнгийн хэмжээгээр урамшуулал тооцон олгож эхэлснээс шийдвэр гүйцэтгэгчид зөвхөн мөнгөн урамшуулал бүхий гүйцэтгэх баримт бичигт илүү өөрийн чиг үүргийг чиглүүлэн ажиллаж, бусад төрлийн хүүхдийн тэтгэлэг, төсөвт төвлөрүүлэх төлбөр, эрүүгийн хэргийн хохирол, төлбөрийг шийдвэрлэх чиг үүрэг буурсан бөгөөд гүйцэтгэх баримт бичигт жигд, хуваарьтайгаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах шаардлага, нөхцөл буурах, үүнтэй уялдан нийгэмд сөрөг үр дагаврыг бий болгож эхэлсэн.

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны явцад шийдвэр гүйцэтгэгч нь өдөр тутам төлбөр төлөгч, бусад этгээдийн зүй бус үйлдэл, эсэргүүцэлтэй тулгарч байдаг хүндхэн төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг тул эдгээр алба хаагчид ажлын үр дүнг дээшлүүлэх тодорхой хөшүүргийн тогтолцоо байх зайлшгүй шаардлага юм.

Шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлын талаарх судалгааны ажлын явцад мөнгөн урамшуулалтай эрх зүйн зохицуулалттай холбогдуулан Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт чиг үүрэг хэрэгжүүлж буй 81 тойргийн 61 шийдвэр гүйцэтгэгчээс асуулгын хуудсаар санал авахад 87.0 хувь үйл ажиллагаанд урамшууллын систем зайлшгүй шаардлагатай гэсэн хариултыг өгсөн.

Энэ нь нэг талаасаа 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд ажиллаж, урамшууллын хуваарилалтын үр дүнг хүртэж байсан шийдвэр гүйцэтгэгчид асуулгад оролцож санал өгсөнтэй холбоотой байж болох ч нөгөө талаас энэхүү төрийн ачаалал ихтэй, хүндхэн чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчдын эрх зүйн байдлыг дээшлүүлэх шаардлага байгааг харуулж байна гэж дүгнэхээр байна.

Хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, эрх зүйн зохицуулалтаас хамаарч шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдал дордсон байх бөгөөд өөрөөр хэлбэл шийдвэр гүйцэтгэгчид нь 1997-2002 он хүртэл хугацаанд цэргийн цолтой ажиллаж байгаад 2002-2018 он хүртэл хугацаанд энгийн орон тоотой ажиллаж, улмаар эрх зүйн зохицуулалт өөрчлөгдсөнөөр 2018 оны 01 дүгээр сараас эхлэн цэргийн алба хаагчид болсон.

Энэхүү өөрчлөлт нь шийдвэр гүйцэтгэгчид сөрөг нөлөөллийг бий болгож, цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу тэтгэвэрт гаргах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж, тэдний эрх зүйн байдалд нөлөөлсөн байна.Тухайлбал: 23 настай эмэгтэй шийдвэр гүйцэтгэгч 1997 оноос хойш тасралтгүй 2018 он хүртэл шийдвэр гүйцэтгэгчээр ажилласан гэж тооцоход 21 жил ажилласан байх бөгөөд үүний 6 жил нь цэргийн цолтой гэж үзвэл 15 жил нь энгийн орон тоонд ажиллаж, өнөөдрийн байдлаар 44 настай эмэгтэй шийдвэр гүйцэтгэгч цэргийн тэтгэвэр, тэтгэмж болон хувь

тэнцүүлэн тэтгэвэр тэтгэмж тогтоох боломжгүй, хуульд заасны дагуу 55 нас хүртэл хугацаанд шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах шаардлага үүсч, хууль тогтоомжийн өөрчлөлтөөс болж шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдал дордсон байна.

Оросын холбооны улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын ижил чиг үүрэг бүхий гадаад улс орны эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд тогтолцооны хувьд төрийн болон холимог систем үйлчилж байна.

Тухайлбал, БНСУ-ын шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлыг судлан үзэхэд шүүгч, прокурорын чиг үүргийг хэрэгжүүлж байсан алба хаагчид тэтгэвэр тогтоолгосноос хойш 4 жилийн хугацаатайгаар шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд, тэдгээрийн нийгмийн хангамж, цалин хөлс өндөр тогтоогдсон байна. Шийдвэр гүйцэтгэгчийн чиг үүргийг шүүх, прокурорын чиг үүргийг хэрэгжүүлж байсан алба хаагчид хэрэгжүүлэх нь эрх зүйн мэдлэг, ур чадварын хувьд алдаа, зөрчил үүсгэхгүй, мэргэшсэн байх зэрэг эерэг үр дүнг шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үзүүлэхээс гадна, тодорхой хугацаатайгаар уг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг онцлог тогтолцоотойгоор үйл ажиллагаа нь явагдаж байна.

ХБНГУ-ын хувьд төрийн чиг үүргийг тодорхой эрх олгогдсон хувийн хэвшлийн шийдвэр гүйцэтгэгчид хэрэгжүүлж, тэдгээр нь гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс хамаарч цалин хөлс, нийгмийн баталгааг шийдвэрлэсэн байна. Шийдвэр гүйцэтгэгчдийн хэрэгжүүлэх ажлын үнэлгээг тодорхой үнэлгээ, хураамжид шилжүүлж, уг хураамжийн үйл ажиллагаагаар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх байр, бичиг хэрэг, бусад зардлыг шийдвэрлэн ажилладаг онцлогтой.

Дээрх 2 улсын шийдвэр гүйцэтгэгчдийн чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй холбоотой гомдол, маргааныг шийдвэр гүйцэтгэлийн шүүх хянаж, дуудлага худалдаа зэрэг зарим төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шүүх хэрэгжүүлдэг онцлог эрх зүйн зохицуулалт, тогтолцоотойгоор чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Манай улсын хувьд тодорхой цаг хугацаанд шийдвэр гүйцэтгэгчдэд мөнгөн урамшууллын тогтолцоо үйлчилж байсан ч үйл ажиллагаанд тодорхой эсрэг үр дүн бий болоогүйгээс эрх зүйн зохицуулалт шинэчлэл хийж, уг тогтолцоог халсан хэдий ч шийдвэр гүйцэтгэгчдийн эрх зүйн байдлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага, үндэслэл үйл ажиллагааны явцад үүсч байна.

Иймээс шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэжлийн түвшин, ур чадварт нийцүүлэн мөнгөн урамшууллын тогтолцоо бий болгох, эдгээр алба хаагчдад зэргийн нэмэгдэл олгох зэргээр эрх зүйн байдалд дээшлүүлэх шаардлагатай байна.

САНАЛ

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг зохицуулсан хууль тогтоомжийг судалж, дараах байдлаар боловсронгуй болгох саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 287 дугаар зүйлийн 287.8 дугаар зүйлд алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин бусад нэмэгдлээс бүрдэхээр хуульчилсан байна. Хуульд заасан бусад нэмэгдлээс шийдвэр гүйцэтгэгчид хамаарах нэмэгдлийг авч үзэхэд төрийн тусгай алба хаасан хугацааны, албан ажлын онцгой нөхцөлийн, эрдмийн зэрэг, цолны, мэргэжлийн зэргийн гэсэн төрлүүд байгаагаас мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгогдоогүй байна. Хуульд зааснаар уг нэмэгдлийг хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан ч холбогдох эрх зүйн зохицуулалт батлагдаагүй, хуулийн хэрэгжилт хангагдаагүй байна.

Иймд мэргэжлийн зэргийн нэмэгдлийг шийдвэр гүйцэтгэгчид зайлшгүй олгох шаардлагатай бөгөөд тухайн шийдвэр гүйцэтгэгчдийн мэргэжлийн зэргийн ур чадвар, эрх зүйн мэдлэг боловсролыг тодорхой шалгуурын дагуу дүгнэн тогтоодог эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

1. Мэргэжлийн зэрэг тогтоох шалгуур, үндэслэлийг бий болгосноор шийдвэр гүйцэтгэгчид өөрийн тогтоосон зэргийг ахиулах чиглэлээр эрх зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх, нөгөө талаар шийдвэр гүйцэтгэгчид олгогдох цалин хөлс, бусад нэмэгдэл нэмэгдэж эрх зүйн байдлыг дээшлүүлэхэд нэг хөшүүрэг болох юм;

2. Шийдвэр гүйцэтгэгчээр энгийн ажилласан жилийг цэргийнээр ажилласанд тооцох чиглэлээр нэг удаагийн үйлчлэлтэй эрх зүйн акт гаргах боломжийг судлан, хэрэгжүүлэх;

3. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг чанартай гүйцэтгэх, ажлын ачааллыг багасгах үүднээс шийдвэр гүйцэтгэлийн хэлтэс, тасагт туслах ажилтны орон тоо бий болгож, цалингийн санг шийдвэрлүүлэх.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРААС МЭРГЭЖИЛ, МЭДЛЭГЭЭ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛГООР СУРГАЛТАД ХАМРАГДАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ



М.ОДБАЯР
Захиргааны удирдлагын газрын хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас сургалтын чиглэлээр байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, бэлтгэгдсэн хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх давтан болон мэргэшүүлэх сургалтын богино, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх мөн алба хаагчдын боловсролын түвшинг нэмэгдүүлэх зорилгоор гадаадын болон дотоодын их, дээд сургууль, удирдлагын академид элсэн суралцуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 2020 оны эхний хагас жилд хийгдсэн ажлын үр дүнд суурьлан дүн шинжилгээ хийгдсэн болно.

Abstract: The Judicial Decision Enforcement Agency prepares human resources to meet the needs of the organization in the field of training, implements short, medium and long-term training programs to increase the knowledge and skills of trained human resources, and raises the level of education of foreign and domestic universities. The analysis is based on the results of the first half of 2020 in the implementation of key functions such as enrollment in universities and management academies.

Түлхүүр үг: Сургалт, мэргэжил, мэргэжлийн ур чадвар, урт хугацааны сургалт, богино хугацааны сургалт

Keywords: Training, profession, professional skills, long-term training, short-term training

Албаны сургалтын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/197 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2019-2020 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан, нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан.

Сургалтын тайланг эхний хагас жилийн байдлаар нэгтгэхэд харьяа анги, байгууллагууд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын дунд 2019-2020 онд явуулах сургалтын хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, алба хаагч бүрийг хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хичээл сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажилласан байна. Тухайлбал:

405 дугаар хаалтай хорих анги /Тусгай нэгж/ нь “Сэтгэл зүй, хүний хөгжлийн шинэ эхлэл төв”, “EDU CAMPUS STORY HUB” төв зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран алба хаагчдад сэтгэл зүйн боловсрол олгох болк сургалтыг үе шаттай зохион явуулсан;

407 дугаар нээлттэй хаалттай хорих анги нь цахим хэлбэрээр орж буй видео хичээлээр сургалтын бааз үүсгэн цаашид алба хаагчдын үйл ажиллагаанд хэрэглэхээр бэлтгэсэн;

409 дугаар хаалттай хорих анги нь зохиомол нөхцөл байдал үүсгэн тактик ажиллагааны сургалтыг байгалын хүнд нөхцөлд үе шаттай зохион байгуулсан;

Дархан-Уул аймаг дахь ШШГГ- 445 дугаар нээлттэй хорих анги нь нийт алба хаагчдын мэдлэг боловсролын түвшинг тогтоож багт хуваааж өөр хооронд нь уралдуулан бүх алба хаагчдын идэвхи оролцоог нэмэгдүүлсэн ба нэг нь нөгөөдөө тавих анхаарал сайжирсан;

Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги нь мэргэжийн багштай ажлын байрны сургалт зохион байгуулах хамтран ажиллах гэрээ байгуулан нийт алба хаагч нарт сургалтыг зохион байгуулсан;

Ховд аймаг дахь ШШГГ- 457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь Ховд их сургуулийн мэргэжийн багштай ажлын байрны сургалт зохион байгуулах хамтран ажиллах гэрээ байгуулан нийт алба хаагч нарт сургалтыг зохион байгуулсан;

Дорнод аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь Дорнод аймгийн төрийн байгууллагуудын дунд Монгол бичгийн “Цэвэр бичигтэн” шалгаруулах аян зарласан;

Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх албадан хөдөлмөр хийлгэх газар нь нийт алба хаагчдын дунд англиар харилцдаг групп чат үүсгэн хөгжилтэй үр дүнтэй арга хэрэгсэлээр шинэ үг сурсан зэрэг шинэлэг байдлаар сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн нийт анги байгууллага нь “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалт”-ыг 100%, “Бие бялдарын бэлтгэлжилтийг хангах сургалт” -ыг 97%, “Шинээр батлагдсан хууль, журам заавар, нэмэлт өөрчлөлтийн талаарх сургалт” -ыг 95%, “Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшлүүлэх сургалт”-ыг 85%-ийн биелэлттэй зохион байгуулж, хөтөлбөрийг бүрэн хангаж ажилласан байна.

Коронавируст халдварын нөхцөл байдал, Улсын онцгой комиссын шийдвэрээс шалтгаалан нийт анги байгууллага, салбар нэгжүүд сургалтыг зайны болон цахим хэлбэрт шилжүүлэн зохион явуулсан.

Зайны болон цахим хэлбэрээр явуулахад цаг хугацаа, төсөв санхүү, заал багтаамж, бие даан судлах, иргэдэд хүндрэл, чирэгдэл учирахгүй байх ач тустай боловч хичээлийн ерөнхий ойлголт авч буй байдал адил бус өөр өөрийн ойлголтоор хүлээн авсан байна.

Дээрх сургалтын хөтөлбөрийн хүрээнд дараах төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс, салбар нэгжийн дотоод хяналт шалгалт, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан мэргэшүүлэх сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн нийт 50 алба хаагч хамрагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/23 дугаар тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хорих анги, хэлтэс, салбар нэгжийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх цахим сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад нийт 78 алба хаагч хамрагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа А.Намсамандын өгсөн үүргийн эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа, төлбөр төлөгч, түүний хөрөнгийг эрэн сурвалжлах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны оролцогч, шинжээч оролцуулахад анхаарах асуудал болон дуудлага худалдааны явцад хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэхтэй холбоотой ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн баталсан хөтөлбөрийн дагуу цахим сургалтыг 2020 оны 3 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд нийт 270 ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт цахим сургалт зохион байгуулсан.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хөрөнгийн мэдээлэл, хугацааны санууулга бүхий алба хаагчдад зориулсан “ШГА мэдэгдэл” нэртэй гар утасны аппликейншныг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, аргачлалын сургалтыг 2020 оны 4 дүгээр сарын 6-10-ны өдрүүдэд нийт 270 ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарт цахимаар болон танхимын сургалтыг зохион байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/42 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх “Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан, харьяа анги, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын англи хэлний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд англи хэлийг үр дүнтэй ашиглах сургалтын тогтолцоог бий болгох зорилгоор “Гадаад хэл- мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны сургалтын хөтөлбөрийг 2020 оны 03 дугаар сарын 05-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний түвшинд анги байгууллага бүр дотооддоо англи хэлний төвүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулан нийт алба хаагч нарт англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулж байна.

Түүнчлэн уг хөтөлбөрийн хүрээнд анги байгууллагуудаас англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй нийт 16 алба хаагчийг шалгаруулан “English one” сургалтын төвд байгууллагын зардлаар суралцуулахаар шийдвэрлэсний дагуу эхний шатны 35 хоногийн сургалт зохион байгуулсан.

Сургалтанд хамрагдагсад нь англи хэлний харилцан ярианы болон бичгийн ур чадваруудыг эзэмшихээс гадна харьяа анги байгууллагуудад англи хэлний анхан шатны сургалтыг зохион байгуулах чадамжтай сургагч багш болж төгсөнө. Цаашид уг хөтөлбөрийн зорилтуудыг шат дараатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

2020 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ДХИС-ийн Удирдлагын академитай хамтран “Удирдах ажилтны манлайлал, ёс зүй” сэдэвт цахим сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдөр харьяа анги байгууллагын харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга, цагдан хорих байрны дарга нарын нэр бүхий 21 алба хаагчдыг хамруулан зохион байгуулсан.

Цаашид тодорхой албан тушаалын нөөцөд авагдсан болон томилогдсон алба хаагчийн ажлын байран дээрх сургалтыг зайны болон бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах бөгөөд сургалтын үр дүнг дээшлүүлэхэд алба хаагчийн идэвх санаачлага чухал бөгөөд энэхүү онлайн сургалт нь Төрийн албаны тухай хуулийн зарчим, шаардлагад нийцсэн ажил болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төв архиваас харьяа 51 анги, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдад мэдээлэл өгч, арга зүйгээр хангах зорилгоор “АРХИВ, АЛБАН ХЭРЭГ

ХӨТЛӨЛТ”-ийн чиглэлээр цахим сургалтыг видео хурлын “Zoom” вэб сайтыг ашиглан 2020.05.14-ний өдөр зохион байгуулласан.

Тус сургалтаар 2020 оны 04 дүгээр сард шинэчлэгдэн батлагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль” болон “Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэхэд анхаарах асуудал”, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, арга зүй”, “Баримт бичгийн стандарт” сэдвийн хүрээнд Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын мэргэжилтэн Ш.Дариймааг урьж, албан хаагчдад мэдээлэл, арга зүйн зааврыг өгч ажилласан болно.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Д.Одсэрын өгсөн үүргийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 20,22,25-ны өдрүүдэд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 11 ахлах шийдвэр гүйцэтгэгч, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 44 шийдвэр гүйцэтгэгч нарт хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлголтоор хэрэгжүүлэхтэй холбоотой чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулласан.

Алба хаагчдын богино хугацааны сургалтын талаар:

Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллах байгаа нэр бүхий 57 алба хаагчид амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардаж авсан.

Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Захиргааны удирдлагын газрын хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Ж.Отгонсайхан, Хорих ял эдлүүлэх албаны Гүйцэтгэх ажлын хэлтсийн Цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б. Баатардаш нар амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардаж авсан.


Мөн “Албан хэрэг хөтлөлт” сэдэвт төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх богино хугацааны зорилтот зайн сургалтад 2 алба хаагч /а/х Б.Тэрбиш, д/ч Г.Ганцэцэг/-ийг тус тус нар амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардаж авсан.

Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх зайн сургалтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн мэргэжилтэн, дэслэгч Э.Сайнзаяа амжилттай хамрагдаж гэрчилгээгээ гардаж авсан.

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн, хошууч Б.Золзаяа;

Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Д.Одсэр, төрийн алба

хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад гурван алба хаагч /а/х Т.Даваасүрэн, а/д Э.Шинэ-Эрдэнэ, а/д Х.Дунгармаа/ суралцаж байна.



Дотоод хэргийн их сургуульд суралцагсдын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын өгсөн үүргийн дагуу харьяа хорих анги, байгууллага, салбар нэгжийн хэмжээнд дутагдалтай байгаа мэргэжлийн мэргэшсэн боловсон хүчинг тодорхойлоход iT болон барилгын инженер, эмч, эмнэлгийн ажилтан, санхүү, нягтан бодох бүртгэл дутагдалтай байсан тул дээрх зорилт бэрхшээлийг шийдвэрлэх зорилгоор байгууллагын захиалгаар чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх зорилт тавин нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна. Үүнд:

Байгууллагын захиалгаар суралцах нөхцөл боломжийг системийн хэмжээнд зарлан, шалгаруулалтад нэрс авах зорилгоор 3 удаа албан мэдээ авч явуулсан. Түүнчлэн анги байгууллагын сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүдтэй тогтмол холбогдож ерөнхий мэдээлэл авч ажилласан.

Анги байгууллагаас нийт 92 алба хаагч, 17 хүүхдийн санал ирсэнийг ангилж үзвэл:

- МУИС-ийн “Бизнесийн сургууль”-д нягтлан болдох бүртгэл, санхүү, эдийн засагч мэргэжлээр нийт 54 иргэнээс 45 алба хаагч, 9 сурагч;
- ШУТИС-ийн “Барилга, архитектур сургууль”-д барилгын инженер мэргэжлээр нийт 15 иргэнээс 11 алба хаагч, 4 сурагч;
- ШУТИС-ийн “Мэдээлэл, холбооны технологийн сургууль”-д IT инженер мэргэжлээр нийт 25 иргэнээс 24 алба хаагч. 1 сурагч;
- АШУҮИС-д эмч мэргэжлээр нийт 4 иргэнээс 2 алба хаагч, 2 сурагч тус тус ирлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын өгсөн үүргийн дагуу Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс, Хүний нөөцийн хэлтсийн нийт 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан урьдчилсан судалгааг хувийн хэрэг, байгууллагын ажил байдлын тодорхойлолт, нас, хүйс, ажилласан жил, мэргэжил боловсрол зэргийг харгалзан болзол шаардлага хангасан нийт 15 алба хаагч, 2 хүүхдийг эхний сонголтод авсан.

Сонгон шалгаруулалтын дүнгээр МУИС-ийн “Бизнесийн сургууль”-д 2, АШУҮИС-д 3, ШУТИС-ийн “Барилга, архитектурын сургууль”-д 1, нийт 6 алба хаагч, иргэд шалгарсан бөгөөд ШУТИС-ийн “Мэдээлэл, холбооны технологийн сургууль”-д IT инженер мэргэжлээр өдрөөр суралцах алба хаагч, хүүхэд байхгүй байна.

Цаашид ерөнхий боловсролын сургууль төгсөж буй алба хаагчдын хүүхдээс ШУТИС-ийн “Мэдээлэл, холбооны технологийн сургууль”-д IT инженер, АШУҮИС-д эмч, ШУТИС-ийн “Барилга, архитектур сургууль”-д барилгын инженер мэргэжлээр тус тус 1 хүүхэд дахин судлаж шалгаруулах шаардлага үүссэн.

Мөн МУИС-ийн “Бизнесийн сургууль”, ШУТИС-ийн “Барилга, архитектур сургууль”, “Мэдээлэл, холбооны технологийн сургууль”, “АШУҮИС”-тай тус тус хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан ажиллаж байна.

2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуультай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Дамдинцэрэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мэргэшсэн эмч, эмнэлгийн ажилтны хэрэгцээ шаардлага тогтмол үүсч байдгыг онцлоод, хоёр байгууллагын хамтын ажиллагааг нийгмээс тусгаарлагдсан хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэхэд чиглүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж, талууд санамж бичигт гарын үсэг зурсан.

2020 оны 06 дугаар сарын 04-ний өдөр МУИС-ийн “Бизнесийн сургууль” Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд хорих ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Ш.Булган, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мэргэшсэн санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажилтны хэрэгцээ шаардлага тогтмол үүсч байдгыг онцлоод, талууд санамж бичигт гарын үсэг зурсан.

ШУТИС-ийн “Барилга, архитектур сургууль”, “Мэдээлэл, холбооны технологийн сургууль”-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурхаар төлөвлөөд байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуульд суралцаж буй алба хаагчдын талаар танилцуулахад:

Бакалаврт: Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн өдрийн ангид 153 сонсогч (*I дамжаанд 35, II дамжаанд 38, III дамжаанд 43, IV дамжаанд 37*);

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн бакалаврын 3 жилийн эчнээ ангид 67 алба хаагч (*I дамжаанд 26, II дамжаанд 22, III дамжаанд 19*);

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 5 жилийн эчнээ ангид 54 алба хаагч (*I дамжаанд 15, II дэмжаанд 21, V дамжаанд 18*);

Магистрт: Дотоод хэргийн их сургуулийн “Гэмт явдал судлал-эрх зүй” магистрын I дамжаанд 16, II дамжаанд 15 нийт 31 алба хаагч;


Удирдлагын сургуульд:

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн “Стратеги-тактик, удирдлага” хөтөлбөрийн магистрын өдрийн сургалтад 2, улирлын сургалтад 3, “Хууль сахиулах удирдлага” хөтөлбөрийн гарагийн сургалтад 2 нийт 7 алба хаагч тус тус суралцаж байна.

Гадаадын их, дээд сургуульд суралцагсдын талаар:

Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа их, дээд сургууль, удирдлагын академид нийт 16 алба хаагч суралцаж байна. /Адъюнктурт-2, магистрт-1, бакалаврт-10, хэлний бэлтгэлд-3/ тус тус суралцаж байна.

Коронавируст халдварын нөхцөл байдал, Улсын онцгой комиссын шийдвэрээр нийт суралцаж алба хаагч, оюутнуудыг Монгол Улс руу татсан болно.



“Харуул хамгаалалтын ажилтан” бэлтгэх сургалтын талаар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн сул орон тоог

нөхөх, ахлагч бүрэлдэхүүний нөөц бүрдүүлэх зорилгоор харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтад хамрагдах хүсэлт гаргасан иргэдийг 2020 оны 01 дүгээр сараас эхлэн бүртгэл судалгаанд хамруулан ДХИС-ийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Б/232 дугаар тушаалаар 210 иргэнийг элсүүлэн суралцуулаж байна.

Энхийг сахиулах ажиллагааны сонгон шалгаруулалтын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүний сонгон шалгаруулалтад хамрагдах 15 алба хаагчдын нэрсийг Зэвсэгт хүчний жанжин штабд хүргүүлж ажилласан болно.

Магистрын диплом хамгаалалтын талаар: Магистрын диплом хамгаалалт, төгсөлтийн баримт бичиг олгох үйл ажиллагааг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор цахим хэлбэрээр зохион байгуулах тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/195 дугаар тушаал гарсантай холбогдуулан Дотоод хэргийн их сургуулийн “Гэмт явдал судлал-эрх зүй” хөтөлбөрийн II дамжааны нэр бүхий алба хаагчдын судалгааны ажлыг эрчимжүүлэх, хамгаалалтад амжилттай хамруулах зорилтын хүрээнд үүрэг чиглэл хүргүүлэхийн зэрэгцээ татан авч хянан, үнэлэлт, дүгнэлтийг мэргэжлийн арга зүй хүрээнд өгч ажиллсан.

Цаашид анхаарах зүйл, хэрэгжүүлэх санал зөвлөмж







Албаны сургалтыг сайжруулах чиглэлээр:

Албаны сургалтыг зохион байгуулахдаа зөвхөн хөтөлбөрийн төлөвлөлтөд анхаарч, тухайн хөтөлбөрт хамрагдсан алба хаагчийн эзэмшсэн мэдлэгт ач холбогдол өгч үнэлж байгаа нь зөв боловч хамгийн чухал зүйл болох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш, багшийн заах арга зүй, сэдвийн агуулгад анхаарал хандуулахгүйгээр бид энэ үйл ажиллагааг зохион байгуулж үнэлж дүгнэж байгаа нь учир дутагдалтай.

Иймд 2020-2021 оны албаны сургалтыг төлөвлөхдөө энэ тал дээр онцгой анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд “Сургалтын төв”-тэй болох. Сургалтын төвийн асуудал амар хялбар шийдэгдэх боломжгүй, цаг хугацаа, төсөв мөнгө шаардлагатай тул эхний ээлжинд сургагч багш бэлтгэх.

Сургагч багшийг тухайн ажил мэргэжилдээ мэргэшсэн, бусдыгаа манлайлан ажилладаг, бусдад мэддэг, чаддаг зүйлээ чин сэтгэлээсээ зааж сургах хүсэлтэй, чадвартай алба хаагчдыг сонгон шалгаруулж сургалтын багийг бүрдүүлснээр анги байгууллагын байрлал дээр болон бүсчилсэн байдлаар явж хичээл сургалтыг зохион байгуулах боломж бүрдэнэ.

Сургагч багшаар сонгогдсон алба хаагчдад заах арга зүйн сургалт зохион байгуулах мөн цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Алба хаагч нэг бүрийн ажил, амьдралд хамгийн хэрэгцээтэй сэдвүүдийг сонгож Модуль сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь үр дүнтэй.

Нийт алба хаагчдаас авсан санал асуулга болон анги байгууллагын сургалтын үйл ажиллагааг гардан зохион байгуулж буй сургалт хүний нөөц хэвлэл мэдээлэл дотоод ажил хариуцсан мэргэжилтэн болон удирдлагууд Сэтгэл зүй, харилцаа хандлага, стрессийг удирдан чиглүүлэх, гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаатай хамааралтай чиглэлийн сэдвүүдийг хамгийн их хэрэгтэй байна гэдгээ илэрхийлж байв.

2020-2021 оны сургалтын төлөвлөгөөнд Сэтгэл зүйн багц сургалтыг энэ чиглэлийн оношилгоо, зөвлөгөө, сургалтыг цогцоор нь явуулдаг мэргэжлийн байгууллагатай хамтран бүх анги байгууллага дээр биш юм гэхэд томоохон анги байгууллага дээр хэрэгжүүлж ажиллах.

Хувь хүн бүр сэтгэл зүйн хувьд тайван амгалан, эрүүл байх нь ажилдаа хандах хандлага цаашлаад ажлын бүтээмж хамт олны уур амьсгалд хамгийн эерэг байх нөхцөл бүрдэх юм.

Гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаатай алба хаагчдыг танилцуулах, туршлага солилцох.

Ач холбогдолтой сэдвүүдээр мэргэжпийн багш, мэргэжлийн баг хамт олноор видео хичээл бэлтгэж, анги байгууллагад тараах.

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах англи хэл дээрх мэргэжлийн үг хэллэг бүхий гарын авлага боловсруулж анги байгууллагад тараах.

ШШГЕГ-ын хэмжээнд цахим сургалтын нэгдсэн системтэй болох.

ХҮНИЙ ЭРХ БА ХҮНИЙ НАЙМАА



Ж.УУГАНЧИМЭГ
Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, ахмад

Товч агуулга: Хүний наймаа нь олон улсын анхаарлыг сүүлийн үед ихээр татах болжээ. Уг асуудал нь зохион байгуулалттай гэмт хэрэгтэй гол төлөв холбоотой бөгөөд түүний улмаас хүний суурь болон бусад эрхүүд ноцтойгоор зөрчигдөж байдаг. Энэхүү нийтлэлээрээ уг гэмт хэргийн шалтгаан нөхцөл, үйлдэгдэж буй хэлбэрүүдийн талаар, түүнийг хэрхэн таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар өөрийн санал бодлоо хуваалцахыг зорьлоо.

Abstract: Trafficking in human beings has recently attracted international attention. The problem is mainly related to organized crime, which seriously violates basic human and other rights. This article aims to share my views on the causes and forms of the crime, its forms, and how to stop and prevent it.

Түлхүүр үг: Хүний наймаа, хүний эрх, зөрчил, үндэстэн дамнасан гэмт хэрэг,бэлгийн мөлжлөг,хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтэн нууцаар тээвэрлэх, албадан гэрлэлт, хохирогч

Keywords: human trafficking, human rights, conflict, transnational crime, sexual exploitation, labor exploitation, secret transportation of organs, forced marriage, the victim

Хүний наймаа нь хүний үндсэн эрхийг ноцтой зөрчдөг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай хүнд гэмт хэрэг юм. Түүнээс гадна хүний наймаа нь Европ болон Ази тивд маш ашигтай бизнес болтлоо газар авсаар байна. Хүний наймаа нь бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтэн нууцаар тээвэрлэх, албадан гэрлэлт зэрэг өөр өөр зорилготой байдаг. Уг гэмт хэргийн хохирогчид нь эмзэг давхрагийн хүмүүс байдаг бөгөөд ихэнхдээ хүний наймаачид тэднийг эрхшээлдээ оруулахын тулд гэр бүлийнхэнд нь хүч хэрэглэхээр заналхийлдэг байна. Нөгөө талаар хохирогчдын очсон улсад нь цагдаагийн байгууллага авилгад автсан, ямар нэгэн байдлаар холбогдсон байдаг зэрэг шалтгаанаар эрхээ хамгаалуулах боломж хомс байдаг байна.

Дэлхий нийтэд уг гэмт хэргийн үйлдэгдэж байгаа байдлыг авч үзэхэд бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтэн нууцаар

тээвэрлэх, албадан гэрлэлт зэрэг өөр өөр зорилготойгоор үйлдэгдэж байна. Уг гэмт хэргийн хохирогчид нь дийлэнхидээ эмзэг давхрагийн хүмүүс байдаг бөгөөд ихэнхдээ хүний наймаачид тэднийг эрхшээлдээ оруулахын тулд гэр бүлийнхэнд нь хүч хэрэглэхээр заналхийлдэг байна.

Хүний наймааны хохирогчид хангалттай хамгаалалт авж чаддаггүйгээс гадна бусдын эрхшээл дор үйлдсэн үйлдлийнхээ төлөө гэмт хэрэгтнүүдтэй адил ял шийтгүүлдэг байна. Энэ нь тэдний цагдаагийн байгууллагад итгэх итгэлийн алдагдуулж, прокурорууд той хамтарч ажиллахаас зайсхийх нэг нөхцөл болдог байна. Үүний үр дүнд гэмт хэрэгтнүүдийн өширхөлтөөс айсан хохирогчид мэдүүлэг өгөхөөс татгалздаг. Хэдий тэд мөрдөн байцаах ажиллагаанд оролцохоор зөвшөөрдөг ч, цагдаа болон шүүхийн өмнө мэдүүлэг өгөх давхар бэрхшээлтэй тулгардаг. Ингэснээрээ хохирогчид өөрсдөд нь тохиолдсон зүйлсээ дахин дахин санан дурсах шаардлагатай болдог байна. Эцэст нь ихэнх хохирогчид өөсдийгөө хохирогч гэж үздэггүй учир цагдаагийн байгууллагад ханддаггүй байна. Тэвчишгүй нөхцөлд амьдардаг хэдий ч тэд эх орондоо үлдсэн хүмүүстэй харьцуулахад хамаагүй дээр нөхцөл байдалд байна гэсэн хандлагатай байдаг байна. Иймээс хүний наймааны эсрэг авах арга хэмжээг үр дүнтэй байлгахын тулд эх үүсвэр болж байгаа оронд дотоодын зохицуулалт хийх шаардлагатай юм.

Манай улсын 2019 оны хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тайлангаас үзэхэд Засгийн газар хүний наймааны хохирогчдыг хамгаалах хүчин чармайлтаа нэмэгдүүлсэн бөгөөд төрөөс 3 жил дараалан хохирогч хамгаалах ажилд санхүүжилт олгоогүй байсан бол хохирогч хамгаалах үйлчилгээний дийлэнхийг үзүүлдэг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцдэг ТББ-уудад 95 сая төгрөгийн (35,950 ам.доллар) санхүүжилт өгсөн нь тун олзуурхууштай дэвшилтэт зүйл болсон нь ажиглагдаж байна. Монгол Улс ард иргэдээ хүний наймаанаас урьдчилан сэргийлж, хохирогчийг хамгаалах хүчин чармайлтаа сайжруулах зорилгоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2017-2021) болон үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.[1] Тухайлбал: 2018 онд төрөөс тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд 709 сая төгрөг (268,260 ам.доллар) төсөвлөсөн байна (2017 онд төсөв байгаагүй). Энэхүү төсвөөр хил хамгаалах байгууллагууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчгүйгээр хилийн дээс алхаж буй 167 монгол хүүхдийг хүний наймааны шалгуур үзүүлэлтийн дагуу шалгахуйц цагаачлал, харьяатын албаны шинэ програм хангамжийг суурилуулж, хэрэглээнд оруулсан байна. Хэдийгээр эдгээр хүүхдүүд дунд хүний наймааны хохирогч илрээгүй ч, хил гаалийн ажилтнууд тэдний паспортанд яаралтай тусламж шаардлагатай үед хэрэглэх консулын холбоо барих мэдээлэл

[1] Хүн худалдаалах асуудлаархи төлөв байдлын 2019 оны тайлангаас....

бүхий хуудсыг хавчуулж, үргэлжлүүлэн хянах зорилгоор биометрийн хувийн өгөгдлийг хууль сахиулах байгууллагад илгээжээ.

Сүүлийн 5 жилийн хугацаанд хүн худалдаалах гэмт хэрэгтнүүд Монгол улсын нутаг дэвсгэрт дотоод, гадаадын хүний наймааны хохирогчдыг мөлжиж, улмаар хилийн чанад руу гаргаж байна. Гэмт этгээдүүд хүний наймааны хохирогч болсон гадаад иргэдийг Монгол улсаар дамжуулан Орос, Хятад зэрэг улс руу наймаалцдаг байж болзошгүй байна. Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг албадан хөдөлмөрлүүлэхээр Хятад, Казакстан, Норвеги, Швед, Турк улсуудад, харин бэлгийн мөлжлөгт ашиглахаар Бельги, Камбож, Хятад, Герман, Хонконг, Япон, Макао, Малайз, Өмнөд Солонгос, Швед, Турк, АНУ руу болон Монгол Улс дотроо худалддаг байна. Хүний наймаачид зарим үед хар тамхи, олон нийтийн хуурамч сүлжээ, ажлын байрны цахим зар, англи хэлний хөтөлбөрүүд зэргийг ашиглан хохирогчдыг хууран мэхлэх замаар бэлгийн мөлжлөгт татан оруулдаг ажээ. [2]Хөдөө орон нутгийн ба эдийн засгийн хувьд ядуу хорооллын хохирогч нар Улаанбаатар хотод, аймгийн төвүүдэд болон хилийн ойр орчим бэлгийн мөлжлөгт олноороо өртөж байна. Иргэний нийгмийн байгууллагын сүүлийн үед хийсэн судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэл нь ихэнх монголчуудыг хөдөлмөр эрхлэлтийн аюултай сонголт хийхэд хүргэж, хүний наймааны хохирогч болгож, хүн худалдаалдаг гэмт этгээдүүдийн гарт ороход нь нөлөөлж байна гэжээ.[3]

Охид, эмэгтэйчүүд массажны газар, хууль бус эмсийн хүрээлэн, зочид буудал, баар цэнгээний газар, караоке клубүүд болон зарим тохиолдолд орон нутгийн цагдаагийн ажилтнуудын гар бие оролцсон байдлаар бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий хүний наймаанд дотооддоо өртөж байна. Трансжендэр эмэгтэйчүүдийг албан салбарт хөдөлмөр эрхлүүлэхээс гадуурхдаг нийгмийн жигшил зэвүүцэл өргөн тархсан учраас тэд бэлгийн мөлжлөгийн зорилго бүхий хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй. Япон, Өмнөд Солонгос улсын жуулчид хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд ирдэг гэж өмнөх жилүүдэд тайлагнаж байсан бол иргэний нийгмийн зарим бүлгүүдийн мэдээлж байгаагаар энэ явдал улам газар авсан байж болзошгүй байна.Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа Хятад-Монголын хилийн эргэн тойронд хүн худалдаалах гэмт хэргийн эрсдлийг нэмэгдүүлж байна. Өмнөговь аймагт Хятадын хилээр нүүрс тээвэрлэж буй ачааны машины жолоочдын паспортыг ажил олгогчид нь тээврийн хэрэгслийн

[2] Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан 2017. 27 дугаар тал

[3] Мөн тэнд...

барьцаа болгож хураан авч байгаа нь тэднийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх хүчин зүйл болж байна. Эдгээр жолооч нар хилээр нэвтрэх зөвшөөрөл авч, Хятадад нүүрсээ хүргэж өгөх хүртэл хэдэн долоо хоног, хэдэн сарын туршид хагас нойртойгоор ачааны машины цуваанд байнгын хүлээлгэнд зогсдог байна. Хүргэлт хоцроход үйлчлүүлэгчид цалин хөлсийг нь бууруулдаг учир ийм алдагдал нь тэднийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлд оруулдаг байна. Залуу охид, эмэгтэйчүүд уул уурхайн компаниудыг Хятадын хилтэй холбодог нүүрс тээвэрлэх зам дагуу хил нэвтрэхээр хүлээж буй жолооч нарт болон уул уурхайн жижиг тосгон, хотууд, Өвөр Монголын хил дагуух шөнийн цэнгээний газруудад биеэ үнэлж ашиглуулах эрсдэл өндөр байна. Уул уурхайд ажиллаж буй ажилчид урт хугацааны ээлжийн гарааны үеэр үр хүүхдээ гэртээ орхисноор тэд бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд орж байна. Түүнчлэн бага насны хүүхдүүд бичил уурхайтай холбоотойгоор албадан хөдөлмөр эрхлэлтийн мөлжлөгт өртөж байна.

Зарим хүүхэд хүчээр гуйлга гуйх, хулгай хийх болон хурдан морь унах, мал маллах, эсвэл хогийн цэг дээр хог түүх, барилга зэрэг эдийн засгийн албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байна. Зарим тохиолдолд гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдийг хүчээр хөдөлмөр эрхлүүлж бэлгийн мөлжлөгт оруулахад хамсаатан болж байна. Эцэг эхийнх нь гарын үсэг зурж байгуулсан гэрээний дагуу ажиллаж буй уран нугараач Монгол охидыг гол төлөв Монгол, Турк, мөн цөөн тоогоор Хонконг, Сингапурт албадан хөдөлмөр эрхлүүлж байна. Монгол хөвгүүд Хятад улсын хилийн боомт дээр хурдан морь унаач болон циркийн жүжигчнээр тодорхойгүй хугацаагаар ажиллаж, 6 сар тутам хүн дагуулж гэрт нь очуулах гэсэн нөхцөлтэйгөөр ажиллуулдаг нь хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд хүргэж байна. Ийнхүү олон давтамжтай хилийн дээс алхуулж нүүлгэх нь тэднийг хүний наймаанд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Монгол эмэгтэйчүүдийг Хятад эрчүүд, мөн сүүлийн үед давтамж нь буурсан ч Өмнөд Солонгосын эрчүүдэд арилжааны зорилготой зуучлалаар гэр бүл болгосны дараа гэртээ зарцлах, эсвэл хүчээр биеийг нь үнэлүүлж байна. Сүүлийн үед Хятад компаниуд монгол хөвгүүд, эрчүүдийг хөдөө аж ахуйн чиглэлээр хөдөлмөрийн доод хөлснөөс хэт доогуур цалин, тодорхой бус цагаачлал, харьяатын статустайгаар ажиллуулж байгаа нь тэднийг хүний наймаанд өртөх өндөр эрсдэлд оруулж байна. Зарим бичил зээл олгодог Хятад байгууллагууд Монголчуудын паспортыг барьцаанд авдаг нь тэднийг цагаачлал, харьяатын статустай холбоотой албадлагад өртөхөд хүргэдэг байна. Монгол Улсад барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй Хойд Солонгос болон Хятад ажилчид хүний

наймаанд өртөх магадлалтай байна. Тэдний заримыг хилээр орж ирмэгц гэрээг нь өөрчилж, цагаачлал, харьяатын албаны хууль дүрмийг зөрчсөн нэрийдлээр албадан эрхшээлдээ оруулах эрсдэл байна. Хойд Солонгосын ажилчид хүнд, хэцүү нөхцөлд ажиллаж амьдардаг ба чөлөөтэй зорчих, ажлын байраа сонгох эрхгүйн дээр цалин хөлснийхөө өчүүхэн хэсгийг гар дээрээ авдаг байна. Энэ бүхэн бол хүний эрхийг зөрчиж байгаа ноцтой зөрчил юм.

Хүн худалдаалахтай холбоотой асуудлыг илүү үр дүнтэй шийдвэрлэхийн тулд өргөн хүрээнд хэрэгжүүлэх гол арга хэмжээний нэг нь хүний наймааны золиос болсон хөдөлмөр, үйлчилгээнээс ашиг хүртэгчдэд хариуцлага тооцох явдал юм. Үүнийг хүний наймааны хохирогч болно гэдгийг мэдсээр байж, ухамсартайгаар үйлдсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчлах аргаар шийдвэрлэж болно.

Хүн худалдаалах гэмт хэрэгт зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцооны талаар бодит баримтад суурилсан судалгаа, найдвартай мэдээлэл маш бага байдаг. Учир нь эдгээр үзэгдлүүд дэхь хүмүүсийн оролцоо маш далд явагддаг учир шаардлага хангахуйц мэдээлэл цуглуулах бэрхшээлтэй байдагтай холбоотой. Практикт суурилсан, мэдээлэлгүй бол хүний наймааны эсрэг үр дүнтэй арга хэмжээ авах боломжгүй. Судлаачид хүний наймаачдын талаархи мэдээллийн маш том хоосон орон зайг арилгахын тулд гэмт хэрэгтнүүдийн мэдүүлгийг ашиглан хүн худалдаалах үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар илүү их мэдээлэл олж авах, хохирогчдын талаар илүү их мэдээлэл олж авах хэрэгтэй.

Засгийн газрууд хүний наймаа болон хариуцлагтатай ажил олголт, эрхлэлтийн асуудлаар эрсдэл өндөртэй зах зээлүүд хамтын ажиллагаа өрнүүлэх хэрэгтэй. Тодорхой компанийг хөдөлмөрийн мөлжлөгө эрхэлж байгаа хэмээн олон нийтэд ил болгох нь бусад компаниудыг илүү идэвхи санаачлагатай болгоно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сурталчилгааны аян нь зөвхөн эрэгтэйчүүд хүн худалдаалах гэмт хэрэгт оролцдоггүй, эмэгтэйчүүд, түүгээр барахгүй гэр бүлээрээ хамтран үйлддэг гэдэг мэдээллийг түгээх нь чухал.

Эцэст нь ял шийтгэл оногдуулсан гэмт хэрэгтнүүдийн тоо бага хэвээр байгаа нь тухайн улсуудад хүн худалдаалахын эсрэг арга хэмжээнүүдэд авилгын асуудлыг нухацтай хэлэлцсэн эсэхэд эргэлзээ төрүүлж байна, тухайлбал цагдаагийн байгууллага, хил хамгаалах газар, эрүүгийн тогтолцоо, төрийн захиргааны болон бусад зохицуулах салбарууд тухайлбал тээвэр, банк санхүүгийн зэрэг чухал салбаруудад байгаа хууль бус үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний зах зээлд анхаарал хандуулах шаардлагатай юм.


RESEARCH
LINKING
PRACTICE